



**ХУУЛЬ ЗҮЙН
ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН**

2020

**ХҮНИЙ ЭРХИЙН ХАМГААЛАГЧИЙГ
ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛЬ**

Хууль тогтоомжийн хэрэгцээ шаардлагыг урьдчилан

Улаанбаатар хот 2020 он



Судалгааг удирдсан:

Д.Зүмбэрэлхам

ХЗҮХ-ийн Төслийн зөвлөх, Хууль зүйн доктор,
профессор

Судалгааг гүйцэтгэсэн:

Б.Гончигсумлаа

ХЗҮХ-ийн Эрдэм шинжилгээний ажилтан, хууль
зүйн магистр

М.Очирбат

ХЗҮХ-ийн Эрдэм шинжилгээний ажилтан

Судалгааг хянасан:

С.Энхцэцэг

Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Захирал

АГУУЛГА

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ	3
НЭГ. АСУУДАЛД ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН БАЙДАЛ	4
1.1. Асуудлын мөн чанар, цар хүрээг тодорхойлсон байдал	10
1.2. Эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа нийгмийн бүлэг, иргэдийг тодорхойлох	11
1.3. Асуудлыг үүсгэж буй шалтгаан нөхцөл	12
ХОЁР. АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ ЗОРИЛГЫГ ТОДОРХОЙЛСОН БАЙДАЛ	13
ГУРАВ. АСУУДЛЫГ ЗОХИЦУУЛАХ ХУВИЛБАРУУД, ТЭДГЭЭРИЙН ЭЕРЭГ, СӨРӨГТАЛЫГ ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ	14
ДӨРӨВ. ОЛОН УЛСЫН БОЛОН БУСАД УЛСЫН ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТТАЙ ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ	28
ТАВ. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ	32
 ХАВСРАЛТ 1. Хүний эрхийн хамгаалагчийг хамгаалах загвар хуульд тусгагдсан үзэл санаанууд хуулийн төсөл болон бусад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжид тусгагдсан байдал	 35
ХАВСРАЛТ 2. Зохицуулалтын хувилбаруудын үр нөлөөний урьдчилсан үнэлгээ	41
ХАВСРАЛТ 3. Хүний эрхийн хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай холбогдох хуулийн түүвэр судалгаа	58

ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГЫГ УРЬДЧИЛАН ТАНДАН СУДЛАХ СУДАЛГААНЫ ТАЙЛАН¹

*Хүний эрхийн хамгаалагчийн эрх зүйн
байдлын тухай хууль*

Ерөнхий мэдээлэл:

Нэгдсэн Үндэсний Байгууллагаас 1948 онд Хүний эрхийн Түгээмэл Тунхаглалыг баталсан. Хүний эрхийг хамгаалах явцад хүний эрхийн хамгаалагчийн эрх зүйн байдал сул, үйл ажиллагааныхүрээ хязгаарлагдмал, заналхийлэл, дарамт шахалтад өртөж байгааг анхаарч Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейн 1998 оны A/RES/53/114 тогтоолоор “Нийтээр хүлээн зөвшөөрсөн хүний эрх, үндсэн эрх чөлөөг хамгаалах, хөхиүлэн дэмжих хувь хүн, нийгмийн нэгж, байгууллагын эрх, үүргийн тунхаглал” буюу Хүний эрхийн хамгаалагчийн тухай тунхаглалыг баталсан байна.

Монгол Улс Нэгдсэн Үндэстний Байгууллагад гишүүнээр элссэнээсээ хойш “Иргэний болон улс төрийн эрхийн тухай”, “Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай” олон улсын Пакт зэрэг хүний эрхийн талаарх Нэгдсэн Үндэстний Байгууллага болон түүний төрөлжсөн байгууллагуудын олон улсын 30 гаруй гэрээнд нэгдэн орж, үүрэг хүлээсээр ирсэн.

Монгол Улсын Үндсэн хуулийн хоёрдугаар бүлэг “Хүний эрх, эрх чөлөө” гэсэн бүлэгт дээрх үндсэн эрхийг хуульчлан баталгаажуулсан байдаг. Ингэхдээ хүний эрх, эрх чөлөөг хангах, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг төр хариуцахаар үүрэг хүлээсэн.

Монгол Улсад хүний эрхийг хамгаалах үйл ажиллагаа явуулсны төлөө амь нас, бие махбодод нь халдах, заналхийлэх, дарамт шахалтад өртөх зэрэг явдал байгаа нь “Хүний эрхийн хамгаалагч” гэсэн нэгдсэн ойлголт байхгүй, эрх зүйн орчинг хангалттай бүрдээгүй, тусгайлсан хууль тогтоомж байхгүй байгаатай холбоотой гэсэн үндэслэлээр Хүний эрхийн хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслийг боловсруулжээ.

Энэхүү судалгаагаар “Хүний эрхийн хамгаалагчийг хамгаалах” тухай ойлголтыг хуулиар тодорхойлох, хүний эрхийн хамгаалагчийн аюулгүй байдлыг хангах, зөрчигдсөн эрхийг сэргээх, тэдгээрийн үйл ажиллагааг нь зохицуулах, тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд хуулийн төсөл боловсруулах шаардлагатай эсэх талаар Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолоор баталсан хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлалын дагуу гүйцэтгэв.

¹ Судалгааг Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолоор баталсан “Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлал”-ын дагуу Төлбөрийн чадваргүй яллагдагчид үзүүлэх хууль зүйн тусалцааны тухай хуульд тулгамдсан зарим асуудлын хүрээнд боловсруулав.

Судалгааны аргачлал:

Тус судалгааг гүйцэтгэхдээ Засгийн газрын 59 дүгээр тогтоолоор батлагдсан аргачлалын дагуу дараах үе шатыг баримтлан гүйцэтгэв. Үүнд:

1. Асуудалд дүн шинжилгээ хийх;
2. Асуудлыг шийдвэрлэх зорилгыг томъёолох;
3. Тухайн асуудлыг зохицуулах хувилбаруудыг тогтоож тэдгээрийн эерэг болон сөрөг талыг харьцуулан судлах;
4. Зохицуулалтын хувилбарын үр нөлөөг тандан судлах;
5. Зохицуулалтын хувилбаруудыг харьцуулж дүгнэлт хийх;
6. Тухайн зохицуулалтын талаарх олон улсын болон бусад улсын эрх зүйн зохицуулалтын харьцуулсан судалгаа хийх;
7. Зөвлөмж боловсруулах;

Дээрх дарааллын дагуу нэгдүгээрт “Хүний эрхийн хамгаалагчийг хамгаалах”-тай холбогдсон харилцааг судлах, тулгамдсан асуудлыг тодорхойлохыг зорьсон болно. Энэ хүрээнд Монгол Улсын хууль тогтоомжоос гадна Олон Улсын байгууллагаас хүний эрхийн чиглэлээр гаргасан баримт бичгүүд, холбогдох мэргэжилтнүүдтэй уулзалт, ярилцлага хийх, өмнө хийгдсэн социологийн судалгаа, бусад статистик мэдээллийг ашиглав. Ингэхдээ асуудлын мөн чанар, түүний цар хүрээг тогтоож, тухайн асуудлаар эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж буй нийгмийн бүлэг болон тухайн асуудлыг үүсгэж буй шалтгаан нөхцөлийг тус тус тодорхойлов.

Эцэст нь тухайн судалгааны хувилбаруудаас сонгон авсан хувилбарт үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

УРЬДЧИЛАН ТАНДАН СУДЛАХ ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Хүний эрхийн хамгаалагчийг хамгаалах тухай хуулийн төсөл боловсруулах хэрэгцээ, шаардлагыг Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлал² /цаашид Аргачлал гэх/-ын 2.1-д заасан үе шатны дагуу хийж гүйцэтгэлээ.

НЭГ.АСУУДАЛД ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН БАЙДАЛ

1998 онд НҮБ-аас дэлхийн улс орнуудад хүний эрх, эрх чөлөөний хэрэгжилтийг бодитойгоор эдлүүлэхийн төлөө тэмцэж буй хүний эрхийн хамгаалагчийн үйл ажиллагаа, эрх чөлөөг хязгаарлагдах, заналхийлэх, дарамт үзүүлэх тохиолдлууд гарч буйг анхаарч “Нийтээр хүлээн зөвшөөрсөн хүний эрх, үндсэн эрх чөлөөг хамгаалах,

² Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоол. Нэгдүгээр хавсралт.

хөхиүлэн дэмжих, хувь хүн, нийгмийн нэгж, байгууллагын эрх, үүргийн тунхаглал”-ыг батлан гаргасан бөгөөд Нэгдсэн Үндэстний байгууллагын Ерөнхий Ассамблейгаас энэ чиглэлээр үр дүнтэй арга хэмжээ авахыг санал болгож уриалах болсон.³ Энэ дагуу дэлхийн олон улс орон хүний эрхийн хамгаалагчийн үйл ажиллагааны баталгаа, хамгаалалтыг өөрийн орны хууль тогтоомждоо тусгасан боловч хангалтгүй байсаар байна.

Олон улсын байгууллагаас 2016 оны байдлаар 22 улсад хүний эрхийг тайван замаар дэмжсэнийхээ төлөө хүмүүс амь насаа алдаж, 63 улсад нэр төр гутаах ажиллагааны бай болж, дор хаяж 68 улсад тайван замаар үйл ажиллагаа явуулсныхаа төлөө баривчлагдаж, хоригдсон байна. 94 улсад хүний эрхийн хамгаалагчид заналхийлэл, халдлагад өртсөн⁴ гэсэн баримтыг гаргажээ.

Хүний эрхийн хамгаалагч гэдэгт “Гол төлөв хүний эрхийн байгууллагаар нарийн судлуулж, арга хэмжээ авахуулах үүднээс гарч байгаа болон гарч болзошгүй хүний эрхийн зөрчлийн талаар мэдээлэл дамжуулах замаар хүний эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хөндөгдсөн эрхийг сэргээхэд чиглэгдсэн үйл ажиллагаа явуулж байгаа хүн, бүлэг этгээд, байгууллагыг”⁵-ыг ойлгохоор олон улсын хэм хэмжээнд тодорхойлсон байна. Үүнээс үзэхэд хүний эрхийн хамгаалагч нь хүний эрхийн төлөө тэмцэх, хөхиүлэн дэмжих ажлыг бие дааж буюу бусадтай хамтран явуулж буй хувь хүн, байгууллага, албан тушаалтан хэн ч байж болох бөгөөд гагцхүү тэднийг үйл ажиллагаагаар нь “хүний эрхийн хамгаалагч” хэмээн тодорхойлдог байна.⁶

Монголд Хүний эрхийн үндэсний комиссоос 2014 онд шүүгч, прокурор, цагдаагийн байгууллагын албан хаагч, өмгөөлөгч, хэвлэл мэдээллийн байгууллагын ажилтан, сэтгүүлч, иргэний нийгмийн байгууллагын ажилтан, үйлдвэрчний эвлэлийн гишүүн, сонгуульт ажилтан зэрэг 5000 орчим хүнийг хамруулсан судалгааг гүйцэтгэсэн байна. Түүнд хүний эрхийг хамгаалсныхаа төлөө амь нас, бие махбодод нь халдах, заналхийлэлд өртөх, нэр төр алдар хүндэд халдах, сэтгэл санааны дарамт үзүүлэх, цахим хэлбэрээр халдлагад өртөх, мэдээлэл авах боломжийг хязгаарлах, мэдээлэл өгөхөөс татгалзах, үйл ажиллагааг нь үгүйсгэх, үл ойшоох, төвөгшөөх, төрийн байгууллагын зүгээс хүнд суртал гаргах, ялгаварлах, шударга бус хандах, цалин, нийгмийн халамжийг хязгаарлах, үзэл бодлоо илэрхийлэх эрхийг хязгаарлах

Хүний эрхийн хамгаалагчийн тухай хуультай болох нь үнэхээр нэн шаардлагатай байна. Монгол Улсын хувьд иргэний нийгмийн байгууллага хүний эрхийн хамгаалагчийн хуультай болох хүсэлтийг 2 жилийн өмнө тавьсан. Мөн олон улсын байгууллагаас ч бас шаарддаг болсон. Бид дэлхийн жишигт нийцсэн хуультай болох зорилго тавьсан боловч эхний ээлжид ямар ч байсан хуультай болохын тулд тэрхүү шаардлагаа ялимгүй бууруулсан хуулийн төслийг боловсруулаад байна.

Хүний эрхийн үндэсний комиссын төлөөлөл

⁵Нэгдсэн Үндэстний байгууллагын Ерөнхий Ассамблейгаас “Хүний эрхийн хамгаалах, хөхиүлэн дэмжих хувь хүн, нийгмийн нэгж, байгууллагын эрх? Үүргийн тунхаглал.

⁶Хүний эрхийн үндэсний комисс. Судалгаа 38 дахь тал.

зэрэг хүндрэл бэрхшээл тулгарч байдаг байна.⁷

Хүний эрхийн хамгаалагчийг хамгаалах үзэл санаа

Хүний эрхийн хамгаалагчийг хамгаалахын үндсэн суурь ойлголтыг “Нийтээр хүлээн зөвшөөрсөн хүний эрх, үндсэн эрх чөлөөг хамгаалах, хөхиүлэн дэмжих хувь хүн, нийгмийн нэгж, байгууллагын эрх, үүргийн тунхаглал”-аар тодорхойлсон байна. Ингэхдээ хүн бүр ганцаар болон бусадтай эвлэлдэн нэгдэж, үндэсний болон олон улсын түвшинд хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, хүндэтгэн биелүүлэх явдлыг дэмжих, түүний төлөө тэмцэх эрхтэйг онцолжээ. Тунхаглалын хоёр дугаар зүйлд улс бүр өөрийн харьяа нутаг дэвсгэрт байгаа бүх хүнд ганцаар болон бусадтай эвлэлдэн нэгдэж бүх эрх, эрх чөлөөгөө бодитойгоор эдлэх нийгэм, эдийн засаг, улс төрийн болон бусад талбарт шаардагдах бүхий л нөхцөл байдлыг бий болгохын зэрэгцээ хууль, эрх зүйн баталгааг бүрдүүлж өгөхөд шаардлагатай алхмуудыг авч хэрэгжүүлэх замаар хүний бүхий л эрх, эрх чөлөөг хамгаалах, хөхиүлэн дэмжих, хэрэгжүүлэх эн тэргүүний үүргийг хүлээхийг тусгасан байна.

Мөн тунхаглалтай уялдуулан НҮБ-аас Хүний эрхийн хамгаалагчийг хамгаалах загвар хуулийг гаргасан байна. Түүнд хүний заавал эдлэх эрх, түүнийг бодитойгоор хэрэгжүүлэх механизмын талаар дурдаж дараах зорилтыг дэвшүүлжээ. Үүнд:

1. Хүний эрхийг хүн бүрт эсхүл хамтад нь бүх нийтээр үндэсний болон олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөх, хүндэтгэх, хангах байдлыг бэхжүүлэх;
2. Хүний эрх болон үндсэн эрх чөлөөг баталгаажуулах, хөхүүлэн дэмжих болон хамгаалах байдлыг бэхжүүлэх;
3. НҮБ-ын Ерөнхий Ассамблейн Хүний эрхийн түгээмэл тунхаглал болон нийтээр хүлээн зөвшөөрсөн хүний эрх болон үндсэн эрх чөлөөг хөхүүлэн дэмжих хувь хүн, бүлэг хүмүүс, нийгмийн бүх байгууллагын үүргийг хэрэгжүүлэх байдлыг хангах;
4. Хүний эрхийн хамгаалагчийг хамгаалах талаарх бүс нутгийн хэрэгсэл болон болон баримт бичгийг хэрэгжүүлэх талаар хүлээсэнүүрэг амлалтыг баталгаажуулах юм.

Загвар хуульд хүний эрхийн хамгаалагчийн 17 эрхийг тусгасан төдийгүй тэдгээр эрхийг хангах, үр дүнтэй хэрэгжүүлэх механизм бий болгохыг зорилго болгожээ. Ингэхдээ тусгайлан байгуулсан байгууллага байгуулах замаар эсхүл эрх олгогдсон хараат бус байгууллага, нэгж энэхүү чиг үүргийг удирдан зохион байгуулах хувилбарыг дэвшүүлжээ.⁸ Мөн тунхаглалд хүний эрх, эрх чөлөөтэй холбоотой баримт мэдээлэл олж авах эрхийг хангах, эрх нь зөрчигдсөн тохиолдолд нөхөн төлбөрийг олгох, эрх бүхий байгууллагаас хүний эрхийн хамгаалагч болон иргэний нийгмийн төлөөлөгчидтэй зөвшилцөх гэх мэтасуудлыг төрийн байгууллага хариуцахаар

⁷Хүний эрхийн хамгаалагчийн эрхийн хэрэгжилт. Хүний эрхийн үндэсний комисс. 2014 он.

⁸Хүний эрхийн хамгаалагчийг хамгаалах тухай загвар хууль. Дөрөв дүгээр бүлгээс дэлгэрүүлэн үзнэ үү.

тусгасан байна.

Дээр дурдсан “Нийтээр хүлээн зөвшөөрсөн хүний эрх, үндсэн эрх чөлөөг хамгаалах, хөхиүлэн дэмжих хувь хүн, нийгмийн нэгж, байгууллагын эрх, үүргийн тунхаглал”-ийн үзэл санаа болон Хүний эрхийн хамгаалагчийг хамгаалах загвар хуульд заасан 17 эрх бүхэлдээ Монгол Улсын хууль тогтоомжид шууд болон дам байдлаар тусгагдсан гэж дүгнэж болохоор байна. Харин Хүний эрхийн хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуульд дийлэнх нь тусгагдсан байна

/Хүний эрхийн хамгаалагчийн загвар хуульд тусгагдсан 17 эрх Монгол Улсын хууль тогтоомж болон Хүний эрхийн хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төсөлд хэрхэн туссан талаарх харьцуулсан хүснэгтийг хавсралт 1-ээс дэлгэрүүлэн үзнэ үү./

Хүний эрхийг хамгаалахад хуулийн төслийн үзэл санаа бүхэлдээ чиглэгдсэн бөгөөд зарим эрхийг хэрэгжүүлэхдээ /Загвар хуулийн 3, 4.2, 4.3, 9, 11, 12, 24, 28-р зүйл/ орон нутаг, бүс нутгийн түвшинд дэмжих болон хамгаалах санааг дурдсан. Харин хуулийн төслийн 6.1.10-д албан тушаалтан, аж ахуйн нэгжийн удирдлагын үйлдлийн талаар гаргасан гомдлыг бүс нутгийн байгууллагад шийдвэрлүүлэхээр зааснаас бусад тохиолдолд энэ зохицуулалтыг хэрэглээгүй байна.

Хуулийн төслийн 6.1.6 дугаар зүйлд “хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, хангахад шаардлагатай хууль тогтоомжоор төрийн болон бусадбайгууллага, хувь хүний нууцад хамаарахаас бусад мэдээллийг төр, хувийн хэвшил, иргэний нийгмээс аливаа хэлбэрээр хүлээж авах, эрж хайх, олох мэдэх, хэвлэн нийтлэх, хадгалах, бусадтай хуваалцах” эрхийг тусгасан байна. Харин загвар хуульд тусгагдсанаар олж авсан мэдээллийг ашиглах, бусдад түгээх, тараах талаар зохицуулалт байхгүй байна.

Загвар хуулийн 7 дугаар зүйлд заасан “хүний эрх, үндсэн эрх чөлөөтэй холбоотой үзэл санаа, зарчмыг хөгжүүлэх”, 8-р зүйл “Төрийн бус, төрийн болон засгийн газар хоорондын байгууллагатай харилцах эрх”, 15-р зүйл “Айлган сүрдүүлэх болон хилс хэргээр хэлмэгдүүлэхээс ангид байх”, 16-р зүйл “Гүтгэх болон гутаан доромжлохоос хамгаалах”, 17-р зүйл “Соёлын эрхээ хэрэгжүүлэх болон хөгжих эрх”-ийн талаарх зохицуулалтыг хуулийн төсөлд тусгаагүй байна.

Монгол Улс дахь эрх зүйн зохицуулалт

Монгол Улсын Үндсэн хуульд хүний эрхийн хамгаалагчийг хамгаалах талаар тусгайлсан зохицуулалт байхгүй боловч хуулийн оршил хэсэгт “хүний эрх, эрх чөлөө, шударга ёс, үндэснийхээ эв нэгдлийг эрхэмлэн дээдэлж”, Арван ёс дүгээр зүйлд “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.” гэж зааснаас үзэхэд хүний эрхийн хамгаалагчийг хамгаалах суурь ойлголтыг үндсэн хуульд агуулагдсан гэж

тайлбарлах боломжтой.

Үндсэн хуулиас гадна бусад цөөн тооны хууль тогтоомжид хүний эрхийн төлөө тэмцэж буй этгээдэд эрх олгосон, түүнийг хамгаалсан зохицуулалт тусгагдсан байна. Тэдгээрийг дурдвал: Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуулийн 1 дүгээр зүйлд “Энэ хуулийн зорилт нь тайван жагсаал, цуглаан хийх иргэдийн Үндсэн хуулийн эрх чөлөөг баталгаажуулах, жагсаал цуглаан хийх журмыг тогтоох, уул арга хэмжээний үед нийгмийн хэв журам, иргэдийн аюулгүй байдлыг хангахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино”, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 11 дүгээр зүйлд “Иргэн, хуулийн этгээд нь хүний эрх, эрх чөлөө, үндэсний аюулгүй байдал, байгууллагын хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор хууль тогтоомжид нийтэд мэдээлэхийг хориглосноос бусад дараах мэдээллийг энэ хуулийн 3.1-д заасан байгууллагаас авах эрхтэй”, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1-д “Хүүхдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, гэр бүлийн бусад гишүүн хамгаалах үүрэгтэй”.

Улсын их хурлаас 2000 онд Хүний эрхийн үндэсний комиссын тухай хуулийг баталснаар “Хүний эрхийн үндэсний комисс” байгуулагдсан бөгөөд тус хуулиар үйл ажиллагааны зарчим, эрх зүйн үндсийг тодорхойлж, бүрэн эрхээ хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахаар заасан байна. Хүний эрхийн үндэсний комисс нь Монгол Улсын Үндсэн хууль, хууль, олон улсын гэрээнд заасан хүний эрх, эрх чөлөөний тухай заалтын хэрэгжилтэд хяналт тавьж, хүний эрхийг сахин хамгаалах, хөхүүлэн дэмжих⁹ чиг үүрэгтэй байгууллага юм.

Тус хуулийн зорилтод ХЭҮК-ийн үйл ажиллагааны чиглэлийг өргөн хүрээнд тодорхойлсон бөгөөд хүний эрхийн хамгаалагчийн эрхийг хамгаалах чиг үүргийг багтаан ойлгох боломжтой байна. Гэвч хуулийн 13 дугаар зүйлд “Комиссын бүрэн эрх”-ийг тодорхойлохдоодүгнэлт санал гаргах, зөвлөмж гаргах, мэдээллээр хангах, илтгэл бичих гэх мэт¹⁰ хууль тодорхойлсон зорилтоос хязгаарлагдмал хүрээнд үйл ажиллагааны хүрээг тогтоожээ.

Хүний эрхийн үндэсний комиссын тухай хууль дахь энэхүү зохицуулалт нь

⁹Хүний эрхийн үндэсний комиссын тухай хууль. 3.1.

¹⁰ Хүний эрхийн үндэсний комиссын тухай хуулийн 13.

13.1. Комисс нь дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

13.1.1. Монгол Улс дахь хүний эрхтэй холбоотой аливаа асуудлаар санал гаргах;

13.1.2. хууль тогтоомж, захиргааны шийдвэр хүний эрхийн үндсэн зарчимд нийцэж байгаа эсэх талаар зөвлөмж, санал гаргах;

13.1.3. олон улсын хүний эрхийн гэрээний биелэлт, энэ тухай Засгийн газрын илтгэлийг боловсруулахад санал өгөх;

13.2. Комисс нь бүрэн эрхийнхээ хүрээнд дараах үйл ажиллагаа явуулна:

13.2.1. хүний эрхийн асуудлаар судалгаа явуулж, шаардлагатай мэдээллээр хангах;

13.2.2. олон улсын, бүсийн, хүний эрхийн бусад үндэсний байгууллагатай хамтран ажиллах;

13.2.3. Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаар илтгэл бичих;

13.2.4. хүний эрхийн талаарх хууль тогтоомж, олон улсын гэрээг олон нийтэд сурталчлах;

13.2.5. хүний эрхийн боловсрол олгох үйл ажиллагааг дэмжих;

13.2.6. Олон Улсын хүний эрхийн гэрээг соёрхон батлах буюу түүнд нэгдэн орохыг дэмжих.

ХЭҮК-ын үйл ажиллагааны хүрээг нарийн тодорхойлсон зохицуулалт болсон нь ажиглагдаж байна. Иймд хүний эрхийн хамгаалагчийг хамгаалах харилцааг тус хуулийн хүрээнд зохицуулах боломжгүй нь тодорхой харагдаж байна.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хүний эрхийн хамгаалагчийг хамгаалахад чиглэсэн зохицуулалт байхгүй гэж дүгнэж болохоор байгаа бөгөөд ЭХШХШТХ-иар эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд оролцогчдын эрх, тэр дундаа гэрч, хохирогчийн эрхийг хамгаалахад анхаарал хандуулжээ. Харин Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2-д “Шаардлагатай гэж үзвэл гэрч, хохирогчийн хамаарал бүхий этгээдийг энэ хуулийн зохицуулалтад хамааруулж болно.” 5.4-д “Гэмт хэрэг илрүүлэхэд ач холбогдол бүхий мэдээлэл, баримт сэлт өгөх болон бусад байдлаар туслалцаа үзүүлсэн, гэмт хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд гэрчээр оролцоогүй хүн энэ хуульд хамаарагдаж болно.” 19 дүгээр зүйлийн 1-д “Энэ хуулийн 5 дугаар зүйлд заасан гэрч, хохирогчийн амь нас, эрүүл мэндэд хохирол учирч болзошгүй хангалттай үндэслэл байгаа, эсхүл хохирол учирсан бол хамгаалуулах эрх үүснэ.” гэж заасан нь эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны явцад мэдээлэл түгээсэн, гэмт хэргийг таслан зогсоосон гэх мэт хүний эрхийн төлөө тэмцсэн хүнийг бусдын халдлагаас хамгаалах зорилгоор хамгаалалтад авах боломжийг боломжийг нээлттэй зохицуулсан байна.

Хүний эрхийн хамгаалагчийн тухай

НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 1998 оны A/RES/53/144 тогтоолоор баталсан Нийтээр хүлээн зөвшөөрсөн хүний эрх, үндсэн эрх чөлөөг хамгаалах, хөхиүлэн дэмжих хувь хүн, нийгмийн нэгж, байгууллагын эрх, үүргийн тунхаглалд Хүний хүний эрхийн хамгаалагчийг хүн, бүлэг этгээд, байгууллага байхаар тодорхойлсон байдаг. Харин ISHR буюу Олон улсын хүний эрхийн үйлчилгээний байгууллагаас баталсан Хүний эрхийн хамгаалагчийг хамгаалах тухай загвар хуулийн 2 дугаар зүйлд “Энэхүү хуулийн зорилгыг хэрэгжүүлэх хүрээнд “хүний эрхийн хамгаалагч” гэдэгт хүний эрх болон үндсэн эрх чөлөөг орон нутгийн, үндэсний болон олон улсын хэмжээнд хамгаалах, хэрэгжүүлэх талаар дангаараа болон бусадтай хамтран ажиллаж байгаа хувь хүнийг хэлнэ.” гэсэн байна. Тунхаг бичигт хүний эрхийн хамгаалагчийг өргөн хүрээтэйгээр тодорхойлсон бол Загвар хуульд түүний хүрээллийг нарийвчлан зөвхөн хувь хүн байхаар тодорхойлсон.

Өмгөөлөгч, шүүгч, прокурор, улсын байцаагч болон төрийн албан хаагч нар нь хүний эрхийг хамгаалах чиг үүргийг хэрэгжүүлэх эрх бүхий тусгай субъект тул хуулийн үзэл баримтлалд тусгагдсанаар хүний эрхийн хамгаалагчийн ойлголтод хамаарахааргүй байна.

Дээрх субъектийг хэрхэн тусгасныг Үүнээс дурдвал Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 4 дүгээр бүлэг “Шүүгчийн хараат бус байдал, түүнийг хангах баталгаа”, Төрийн албаны тухай хуулийн 5 дугаар бүлэг “Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, баталгаа”, Прокурорын тухай хуулийн 58-61 дүгээр зүйлд прокурорын хууль зүй, эдийн засаг, нийгэм, улс төрийн баталгааг тусгасан байна.

Мөн Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1-д “Өмгөөлөгчид хуулийн хүрээнд мэргэжлийн үйл ажиллагаагаа явуулахад нь дарамт, шахалт үзүүлэх буюу хөндлөнгөөс нөлөөлөх, саад учруулах, заналхийлэхийг хориглоно”, Төрийн бус байгууллагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Төрөөс төрийн бус байгууллагын хууль ёсны эрхийг хамгаална”, Төрийн хяналт, шалгалтын тухай хуулийн 11 дүгээр зүйл “Улсын байцаагчийн бүрэн эрхээ хэрэгжүүлэх баталгаа” гэх мэт салбарын хууль тогтоомжид тусгажээ.¹¹

Дээрхээс үзэхэд Монгол Улсын хууль тогтоомжид хүний эрхийн хамгаалагчийг хамгаалах, үйл ажиллагааг зохицуулсан заалтууд зарим салбарын хүрээнд бага хэмжээтэйгээр хуульд тусгагдсан байна. Мөн уг зохицуулалтууд нь зөвхөн хууль хэрэгжүүлэгч, сахиулагч этгээдэд чиглэсэн байдаг тулхууль бүртхүний эрхийн хамгаалагчийг хамгаалах харилцааг ялгаатай байдлаар тусгасан гэж үзэж болно.

Харин Монгол Улсад шинээр боловсруулж байгаа Хүний эрхийн хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төсөлд хүний эрхийн хамгаалагчид “хувь хүн”-ийг ойлгохоор хүрээг тогтоосон байна.

1.1. Асуудлын мөн чанар, цар хүрээг тодорхойлсон байдал

Хүний эрхийг хамгаалагчийг хамгаалах хэрэгцээ, шаардлагыг тодорхойлох зорилгоор дээрх тулгамдсан асуудалд дүн шинжилгээ хийхэд дараах зөрчлүүдэнхаарал татаж байна. Үүнд:

- Хүний эрхийг хамгаалсан үг хэлсэн, үйл ажиллагаа явуулсныхаа төлөө бусдын халдлага, дарамт шахалтад өртөх;
- Бусдын зүгээс хүний эрхийн хамгаалагчийн нэр төр, алдах хүндэд нь халдах, сэтгэл санааны дарамт үзүүлэх, цахим хэлбэрээр доромжлох;
- Хүний эрхийн хамгаалагчийн үйл ажиллагааг үл ойшоох, төвөгшөөх;
- Төрийн байгууллагын зүгээс хүнд суртал гаргах, хүлээлгэх, асуудлыг шийдвэрлэхгүй удаах;
- Төрийн байгууллага болон хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, эрх бүхий албан тушаалтны зүгээс мэдээллээр хангах үүргээ биелүүлэхээс татгалзах, зайлсхийх, мэдээллийг нуун дарагдуулах.

Эдгээр асуудлыг харгалзан судалгааны цар хүрээг өргөн хүрээнд авч үзэх нь тохиромжтой байна. Өөрөөр хэлбэл хүний эрхийн хамгаалагчийг хамгаалах нэгдсэн тогтогтолцоог хууль тогтоомжоор бий болгох замаар дээр дурдсан бүх асуудлыг шийдвэрлэх нь зүйтэй юм.

¹¹Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль

1.2.Эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа нийгмийн бүлэг, иргэдийг тодорхойлох¹²

Дээр тодорхойлсон цар хүрээтэй холбоотойгоор дараах нийгмийн бүлэг,бусад этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхолхөндөгдөж байна гэж үзлээ.

Эрх ашиг нь хөндөгдөх бүлэг		Нөлөөлж буй хэлбэр
1	Иргэн	Хүний эрхийг хамгаалах зорилгоор үг хэлсэн, үйл ажиллагаа явуулсан болон бүхий л хэлбэрээр тэмцсэн иргэн бүр эргээд бусдын хууль бус халдлагад өртөх бодит эрсдэл байсаар байна.
2	Эрх бүхий байгууллага, албан тушаалтан	Хуулиар хүний эрхийг хамгаалах чиг үүрэг хүлээсэн зарим байгууллага, албан тушаалтны хамгаалах, үйл ажиллагаагаа явуулах эрх зүйн баталгааг сайжруулах, ингэхдээ нэгдсэн тогтолцоогоор нь авч үзэх. Албан тушаалтан /шүүгч, прокурор, байцаагч гэх мэт/-ны хувьд тусгайлан хүлээсэн чиг үүргийг хэрэгжүүлдэг тул иргэнээс ялгаатай авч нь тохиромжтой.
3	Гадаадын иргэн, харьяалалгүй хүн	Хүний эрхийг аливаа нэг улсын харьяаллаас үл хамааран хүн бүр эдлэх эрхтэй байдаг. Хүн бүрХүний эрхийн түгээмэл тунхаглалд заасан бүхий л эрх, эрх чөлөөг арьс үндэс, арьсны өнгө, хүйс, хэл, шашин шүтлэг, улс төрийн болон бусад үзэл бодол, үндэсний буюу нийгмийн гарал, эд хөрөнгө, язгуур угсаа болон бусад байдлын ялгааг эс харгалзан ямар ч гадуурхалгүйгээр эдлэх ёстой. ¹³ Үүнээс дүгнэхэд гадаадын иргэн, харьяалалгүй хүн ч мөн адил хүний эрхийн хамгаалагч байх боломжтой. Өөрөөр хэлбэл гадаадын иргэн, харьяалалгүй хүн хүний эрхийг хамгаалахын төлөө тэмцэх явцдаа бусдын халдлага, дарамт шахалтад өртөх эрсдэлтэй

¹² Аргачлалын 3.1.2-т зааснаар “эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа нийгмийн бүлэг, иргэд, аж ахуйн нэгж, байгууллага, бусад этгээд”-ийг тодорхойлохоор байгаа. Харин манай тохиолдол нь “аж ахуйн нэгж, байгууллага, бусад этгээд”-ийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндөөгүй тул энэхүү судалгааны 1.2 дахь хэсгийн нэршлээс эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөхгүй бүлгийг хассан болно.

¹³Хүний эрхийн түгээмэл тунхаглал. 2 дугаар зүйл.

	болно.
--	--------

Ерөнхийд нь авч үзвэл хүний эрхийн хамгаалагч нь нас хүйс, иргэний харьяалал, ажил мэргэжил зэргээс үл хамааран хүн бүр хүний эрхийн хамгаалагч байх боломжтой тул нийтлэг байдлаар эрх, хууль ёсны ашиг сонирхол хөндөгдөх магадлалтай. Гэхдээ дээрх этгээдүүдийг хэд хэдэн бүрэгт нарийвчлан авч үзэх нь судалгааны ач холбогдолтой бөгөөд дээрх хүснэгтээр дэлгэрэнгүй тайлбарлалаа.

1.3. Асуудлыг үүсгэж буй шалтгаан нөхцөл

Хүний эрхийн зөрчлийн талаар мэдээлэл дамжуулах, зөрчигдсөн эрхийг сэргээх үйл ажиллагаа явуулсныхаа төлөө тодорхой хувь хүн, бүлэг этгээд, албан тушаалтан, засаг захиргааны зүгээс ямарваа дарамт шахалтад өртөх, эрх чөлөөгөө хязгаарлуулах, хувь хүнийх нь эрх зөрчигдөх, хүчирхийлэлд өртөх улмаар үйл ажиллагаагаа хэвийн явуулж чадахгүйд хүрэх тохиолдол өнөөдөр дэлхий нийтийн хэмжээнд байсаар байна.

Жил бүр олон зуун сэтгүүлчид, өмгөөлөгчид, ҮЭ-ийн гишүүд зэрэг хүний эрхийн хамгаалагчид хүний эрхийг хамгаалах үйл явцад оролцсоныхоо төлөө хүчирхийлэл дарамтад ямар нэг байдлаар өртсөн тохиолдохыг гардаг байна. Дэлхийн нийтийн халуун цэгүүд, хүний эрхийг зөрчиж буй улс орнуудад энэ байдал илүү олон, харгис шинжтэйбайгаа төдийгүй ардчилсан улс орнуудад ч цөөнгүй гарсаар байгааг Монголын эмнести интернэшнл байгууллагасудалгаанд¹⁴ онцолсон бөгөөд холбогдох жишээ баримт, тохиолдлуудын талаар тустайлангаас дэлгэрүүлэн үзэх боломжтой байна.

Дэлхийн олон оронд байгаль орчны хүний эрхийн хамгаалагчид хүчирхийлэл, аллага гэх мэт өндөр эрсдэлд өртөж, долоо хоног тутам дунджаар байгаль орчны дөрвөн хамгаалагч амиа алдаж, маш олон айлган сүрдүүлэг, дарамтад өртдөг байна. Улс орны засгийн газрууд хүний эрхийн хамгаалагчдын дуу хоолойг хорихын тулд олон дарангуй тактикийг түгээмэл хэрэглэж иржээ. Жишээлбэл Латин Америкт санал зөрөлдөгчдийг дуугүй болгох хамгийн түгээмэл арга нь “сураггүй алга болгох, бүлэглэн хөнөөх явдал байсан бөгөөд энэ нь цэргийн засаглалынханд мөрөө баллах, хариуцлагаас бултах боломж олгодог байсан талаар дурдсан байна.¹⁵ Хүний эрхийн хамгаалагчид тулгарч буй асуудлуудийг энэхүү тайлангийн 1.1-д “Асуудлын мөн чанар, цар хүрээг тодорхойлсон байдал” хэсэгт дэлгэрэнгүй дурдсан болно.

Хэдийгээр зарим оронд тахлын хэлбэрээр байгаа шиг нөхцөл байдал Монгол Улсад илрээгүй ч байгаль орчны эрхийг хамгаалагчид хууль бус уул уурхай, хулгайн

¹⁴Монгол Улс дахь хүний эрхийн төлөв байдал. Судалгааны тайлан. Монголын Эмнести интернэшнл.

¹⁵Өөрчлөгдөж буй ертөнц дэх хүний эрхийг хамгаалах нь. Эмнести интернэшнл. 2008 он. 18 дахь тал.

агнуурыг эсэргүүцэхийг оролдсон үедээ хүчирхийлэл, сүрдүүлэгт өртсөн тохиолдол олон байгааг НҮБ-ын Тусгай илтгэгч Жон Х.Ноксийн 2017 онд Монгол Улсад хийсэн айлчлалын явцад Хүний эрхийн хамгаалагчийн эрхийн талаарх хийсэн дүгнэлтээс харж болно.¹⁶

Монгол Улсад хүний эрхийн хамгаалагчийн тухай эрх зүйн ойлголт бүрдээгүй, энэ төрлийн асуудлыг тусгайлан авч үздэггүй тул холбогдох зөрчил, баримт сэлт, статистик мэдээг хөтөлдөггүй. Энэ нь цаашлаад хүний эрхийн хамгаалагчийн эрхийн зөрчлийн талаарх судалгаа гүйцэтгэхэд тодорхой бэрхшээл учруулдаг.

Судалгааны явцад Монгол Улсын хувьд хүний эрхийн хамгаалагчийн эрх зөрчигдөхөд дараах нөхцөлүүд нөлөөлж байна гэж үзлээ. Үүнд:

- Хүний эрхийн хамгаалагчийн талаар тогтсон тодорхойлолт байхгүй;
- Хүний эрхийн хамгаалагчийг хамгаалах явдлыг төрөөс жич хуульчлаагүй;
- Хүний эрхийн үйл ажиллагаанд саад учруулах бусад этгээдийн үйлдлийг нарийвчлан тодорхойлоогүй.

Асуудлыг үүсгэж буй шалтгаан нөхцөлийг бууруулахын тулд эхний ээлжид дурдсан асуудлыг шийдвэрлэх нь ач холбогдол ихтэй болно.

ХОЁР. АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ ЗОРИЛГЫГ ТОДОРХОЙЛСОН БАЙДАЛ

Монгол Улсад Хүний эрхийн хамгаалагчийг хамгаалах талаар эрх зүйн ойлголт төлөвшөөгүй бөгөөд үүнээс улбаалан хүний эрхийн хамгаалагчийн эрх зөрчигдөж байгааг өмнө хэсэгт дурдсан.

Иймд аргачлалын 4-т заасны дагуу асуудлыг шийдвэрлэх зорилгыг тодорхойлох хүрээнд холбогдох баримт бичиг, төсөлд энэ төрлийн зорилгыг хэрхэн томъёолсныг авч үзлээ.

Нийтээр хүлээн зөвшөөрсөн хүний эрх, үндсэн эрх чөлөөг хамгаалах, хөхиүлэн дэмжих хувь хүн, нийгмийн нэгж, байгууллагын эрх, үүргийн тунхаглалын зорилгыг товчлон буулгавал Хүний эрх, эрх чөлөөг бүх нийтээр хүндэтгэн сахиж, даган мөрдөхийг дэлхийн орон бүрт хөхиүлэн дэмжих, ямар нэг ялгаварлан гадуурхалт, ялгавартай байдлыг үл тоон хүний эрх, эрх чөлөөг хуваагдашгүй гэдгийг, аюулгүй байдал нь хүний эрх, эрх чөлөөг баталгаатай хэрэгжихэд нягт холбоотой болохыг хүлээн зөвшөөрч эрх чөлөөг шударга, тэгш түвшинд хөхиүлэн дэмжих, хангах, энэхүү эрхийг дэмжих, хамгаалах тэргүүний үүрэг хариуцлага нь төрд хамаарах ёстойг онцлон тэмдэглэж хүний эрхийн хамгаалагчийн эрхийг хамгаалах явдлыг зорилго болгосон байна.

Хүний эрхийн олон улсын үйлчилгээний байгууллагаас (International Service for Human Rights) гаргасан Хүний эрхийн хамгаалагчийг хамгаалах тухай загвар хуульд

¹⁶НҮБ-ын Тусгай илтгэгч Жон Х.Ноксийн Монгол Улсад хийсэн айлчлалын дүгнэлт. 2017.9.27-ны өдөр.

“Хүний эрхийг хүн бүрт эсхүл хамтад нь үндэсний болон олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөх, хүндэтгэх, хангах байдлыг бэхжүүлэх, Хүний эрхийн түгээмэл тунхаглал болон бусад баримт бичигт тусгагдсан эрх чөлөөг хөхүүлэн дэмжих, хүний эрхийн хамгаалагчийг хамгаалах талаарх төрийн үүргийг баталгаажуулах явдлыг зорилго болгосон байна.”

Харин Хүний эрхийн хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлд хуулийн зорилгыг “Хүний эрхийн хамгаалагчийн эрхийг хүндэтгэх, хамгаалах, хангахад оршино.” хэмээн томъёолсон байна. Дээрхээс үзэхэд олон улсын баримт бичиг, загвар хуулийн зорилгод хүний эрхийн хамгаалагчийг хамгаалах бүхий л хэлбэрийг дуйрахыг хичээсэн нь олон улсад үлгэр дуйраалал үзүүлэх, энэхүү эрхийг холбогдох хууль тогтоомжид хангалттай тусгуулах зорилготой холбоотой болов уу. Харин Хүний эрхийн хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслийн зорилго маш товч боловч хүний эрхийн хамгаалагчийн эрхийг “хүндэтгэх”, “хамгаалах”, “хангах” зэрэг гол агуулгыг дурдсан нь зохих түвшинд томъёологдсон байна.

Дээр дурдсан зорилгуудыг жишиг болгон судалгааны явцад дараах зорилгыг дэвшүүллээ. Үүнд:

Зорилго: “Хүний эрхийн төлөө тэмцэж буй этгээдийг бусдын халдлагаас хамгаалах, үйл ажиллагаагаа тогтвортой явуулах боломжоор хангах”

ГУРАВ. АСУУДЛЫГ ЗОХИЦУУЛАХ ХУВИЛБАРУУД, ТЭДГЭЭРИЙН ЭЕРЭГ, СӨРӨГ ТАЛЫГ ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ

Асуудлыг шийдвэрлэх боломжтой хувилбаруудыг тогтоож, Аргачлалын 5-д заасны дагуу зорилгод хүрэх байдал буюу Хүний эрхийн төлөө тэмцэж буй этгээдийг бусдын халдлагаас хамгаалах, үйл ажиллагааг тогтвортой явуулах боломжоор хангаж чадах эсэх, зардал, үр өгөөжийн харьцаа буюу хувилбарыг хэрэгжүүлэхтэй холбоотой гарах зардал, үзүүлэх эерэг өөрчлөлтийг харьцуулан дараах дүгнэлтийг гаргалаа.

Асуудлыг зохицуулж болох хувилбаруудын эерэг болон сөрөг тал

Хувилбар		Зорилгод хүрэх байдал	Зардал, үр өгөөжийн харьцаа	Үр дүн
1	Тэг хувилбарбуюу шинээр зохицуулалт хийхээс татгалзах	Өнөөгийн тулгамдаж буй бэрхшээл хэвээр үргэлжлэх бөгөөд зорилгод хүрэх боломжгүй.	Нэмэлт зардал гарахгүй бөгөөд тулгамдсан асуудал хэвээр үргэлжилнэ.	Үр дүн сөрөг

2	Хэвлэл мэдээллийн хэрэгслээр ухуулга, сурталчилгаа хийх	Зорилгоо биелүүлэхэд зохих хэмжээгээр нөлөөлөх боломжтой. Гэвч өнөөгийн тулгамдаж буй бэрхшээлийгүр дүн сайтай шийдвэрлэх боломжгүй буюу асуудал цаашид хэвээр үргэлжилнэ.	Зардал ихээхэн хэмжээнд шаардагдах бөгөөд ухуулга сурталчилгааг байнга идэвхтэй явуулахыг шаардана. Асуудлыг үүсгэх гол шалтгааныг арилгаж, сөрөг үр дагаврыг бууруулж чадахгүй.	Тодорхой үр дүнд хүрэхгүй
3	Зах зээлийн эдийн засгийн хэрэгслүүдийг ашиглан төрөөс зохицуулалт хийх	Зах зээлийн эдийн засгийн хэрэгслүүдээр одоо байгаа зохицуулалтыг тодорхой түвшинд дэмжих, сайжруулах боломжтой болно.	Зардал шаардагдана. Асуудлыг үүсгэж байгаа гол шалтгааныг арилгахад нөлөөлж, сөрөг үр дагаврыг бууруулж чадахгүй.	Тодорхой үр дүнд хүрэхгүй
4	Төрөөс санхүүгийн интервенц хийх	Иргэдийн хүний эрхийн хамгаалагчийг хамгаалахад тодорхой санхүүжилт шаардлагатай ч хууль тогтоомжгүйгээр бүрэн шийдвэрлэх боломжгүй.	Дан ганц санхүүжилтээр сөрөг үр дагаврыг бууруулж чадахгүй.	Тодорхой үр дүнд хүрэхгүй
5	Төрийн бус байгууллага, хувийн хэвшлээр тодорхой чиг үүргийг гүйцэтгүүлэх	Хүний эрхийн хамгаалагчийг хамгаалах ажиллагаанд төрийн бус байгууллагын оролцоог дэмжих нь чухал ач холбогдолтой. Гэвч өнөөдрийн хууль тогтоомжийн хүрээнд төрийн бус байгууллагын оролцоог нэмэгдүүлэх шаардлагатай.	Иргэний нийгмийн байгууллагыг оролцуулахад зохих хэмжээний зардаг гарах боловч үр ашгаа өгнө.	Зарим үр дүн гарах боловч зорилгоо хүрч чадахгүй
6	Захиргааны шийдвэр гаргах	Хүний эрхийн хамгаалагчийг хамгаалах үйл ажиллагаа нь өргөн хүрээтэй ойлголт тул салбар бүрт зохицуулалт хийх шаардлагыг бий болгодог. Иймд тус суурь харилцааг хууль тогтоомжоор хуульчлан баталгаажуулах нь оновчтой. Зөвхөн захиргааны шийдвэрээр зохицуулах нь зохицуулалтын түвшин харилцан адилгүй, үр	Асуудлыг үүсгэж байгаа шалтгааныг арилгахад тухайлсан тохиолдолд нөлөөлөх боломжтой, сөрөг үр дагаврыг бүрэн бууруулж чадахгүй.	Зарим үр дүн гарах боловч зорилгоо хүрч чадахгүй

		өгөөжгүй болох талтай.		
7	Хууль тогтоомжийн төсөл боловсруулах	Хүний эрхийн хамгаалагчийг хамгаалах, уг үйл ажиллагаагаа тогтвортой явуулах боломжийг бүрдүүлсэн тогтолцоог хууль батлах замаар бий болгох нь хамгийн оновчтой, тогтвортой хувилбар байна.	Зардал гарах боловч энэ нь хувилбар нь асуудлыг үүсгэж байгаашалтгааныг шийдвэрлэхэд хамгийн үр дүнтэй арга зам юм.	Зорилгод оо хүрэх боломжт ой, үр дүнтэй

Хэвлэл, мэдээллийн хэрэгслээр ухуулга, сурталчилгаа хийх замаар иргэд, олон нийтийг мэдээллээр хангах, зах зээлийн эдийн засгийн хэрэгслүүдийг ашиглан төрөөс зохицуулалт хийх, эсхүл төрөөс санхүүгийн интервенц хийх, захиргааны шийдвэр гаргаснаар тухайн асуудлыг үүсгэж байгаа гол шалтгааныг шийдвэрлэж, дэвшүүлсэн зорилгод хүрэх боломжгүй байна.

Иймд асуудлын мөн чанар, нийгмийн хэрэгцээ шаардлага, зохицуулалтын түвшинг харгалзан тулгамдаж буй асуудлыг хуулийн зохицуулалт хийх замаар шийдвэрлэх нь зүйтэй гэж үзлээ.

Ингэхдээ “хүний эрхийн төлөө тэмцэж буй этгээдийг бусдын халдлагаас хамгаалах, уг үйл ажиллагаагаа тогтвортой явуулах боломжоор хангах” зорилгын хүрээнд дараах боломжит зохицуулалтын 3 хувилбарыг дэвшүүллээ.

Хувилбар 1. Хүний эрхийн хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийг батлан энэ төрлийн чиг үүргийг хариуцсан бие даасан байгууллага байгуулах

Хүний эрхийн хамгаалагчийг хамгаалах тухай загвар хуульд “Улс бүр нь хүний эрхийн хамгаалагчийг хамгаалах хангалттай, бүрэн болон үр дүнтэй механизм бий болгох эсхүл бий болгохыг даалгах үүрэгтэй. Энэхүү механизмыг тусгайлан байгуулсан байгууллага эсхүл эрх олгогдсон хараат бус байгууллага нэгж удирдан зохион байгуулах болно” гэж заасныг үндэслэн дээрх хувилбарыг дэвшүүлсэн.

Тус хууль батлагдсанаар салбарын хүрээнд ерөнхий хуульд тулгуурласан хүний эрхийн хамгаалагчийг хамгаалах нөхцөл бүрдэх давуу талтай юм. Иймд Хууль тогтоомжийн тухай хуулийн “Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлалын” 5.6.1, 5.6.2, 6, 7-д зааснаар Зорилгод хүрэх байдал болон зардал, үр өгөөжийн харьцаа, үр нөлөөг харьцуулан дүгнэж хувилбарын хүрээнд тодорхойлъя.

1. Зорилгод хүрэх байдал

Хүний эрхийн хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хууль батлагдан Хүний эрхийн хамгаалагч, хүний эрхийн зөрчил, хүний эрхийн хамгаалагчийн үйл ажиллагаа гэх мэт үндсэн ойлголтууд тодорхойлогдох бөгөөд Хүний эрхийн хамгаалагчийг

хамгаалах бие даасан байгууллага нь хамгаалалтын процессын ажиллагааг нарийвчлан зохицуулж, удирдлагаар хангах боломж нөхцөл бүрэлдэнэ.

Энэ төрлийн хуулийг Индонез, Непал, Мексик, Филиппин зэрэг улс орнууд батлан хэрэгжүүлж байна.Зарим улс орнууд хүний эрхийн хамгаалагчийг хамгаалах бие даасан хуулийг батлах шаардлагагүй гэж үзэх тохиолдол байна.Гэвч практикаас үзэхэд хувь хүний болон бүлгийн эрхийг хүлээн зөвшөөрч тусгайлан хуулиар хамгаалах явдал нь хүний эрхийн хамгаалагчийн эдлэх эрхийг бодитоор хэрэгжүүлэхэд салшгүй холбоотой байна. Өөрөөр хэлбэл хүний эрхийн хамгаалагчдын тухай хууль нь тухайн этгээдийг холбогдох салбар хуулиар хамгаалахад дэмжлэг үзүүлэхээс гадна энэ талын эрхийн мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх, баталгаажуулан таниулахад чухал үүрэгтэй байна.¹⁷

Зардал, үр өгөөжийн харьцаа:

Хүний эрхийн хамгаалагчийг хамгаалах байгууллага байгуулагдаж үйл ажиллагаа явуулснаар хүний нөөцийн зардал, материаллаг зардал, бусад зардал буюу тухайн үйлчилгээг үзүүлэхтэй холбоотой зардлууд гарах бөгөөд энэ нь улсын төсөвт багагүй хэмжээний ачаалал үүсгэнэ.

Хүний эрхийн хамгаалагчийг хамгаалах байгууллагын хувьд ойролцоо төрлийн үйл ажиллагаа явуулдаг Хүний эрхийн үндэсний комиссын орон тоотой ойролцоо байхаар төсөөлж зардлыг тооцож үзлээ.

Хүний эрхийн үндэсний комисс нь 2017 оны 10 дугаар сарын байдлаар нийт 49 хүний орон тоотойгоор үүнээс ажлын алба нь 3 хэлтэс байна. Үүнд:

- Гомдол, хяналт шалгалтын хэлтэс /6 ажилтантай/
- Гомдол, хяналт шалгалтын хэлтэс /7 ажилтантай/
- Захиргаа, хамтын ажиллагааны хэлтэс /10 ажилтантай/

Орон нутагт 21 ажилтан буюу аймаг бүрт 1 ажилтан, нийт 46 хүний бүрэлдэхүүнтэй ажиллаж байна.

Шинээр байгуулагдаж байгаа учир нэгдсэн тогтолцоо бий болгох үүднээс нэг төв байгууллага байх нь хэрэгтэй болно.

Иймд Хүний эрхийн үндэсний комиссын адилаар

- Гомдол, хяналт шалгалтын хэлтэс /6 ажилтантай/
- Гомдол, хяналт шалгалтын хэлтэс /7 ажилтантай/
- Захиргаа, хамтын ажиллагааны хэлтэс /10 ажилтантай/

байхаар төсөөлж зардлыг тооцов.

Хүний эрхийн үндэсний комиссын ажлын алба нь улсын хэмжээнд нийт 49 албан хаагчтай үйл ажиллагаа явуулдаг бөгөөд албан хаагчид нь Улсын их хурал, Ерөнхийлөгч, Засгийн газар, Улсын дээд шүүх, Улсын ерөнхий прокурорын газар, Үндсэн хуулийн цэц, Хүний эрхийн үндэсний комисс, Төрийн албаны зөвлөл,

¹⁷ Specific laws to protect and support human rights defenders. p14

Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, Сонгуулийн ерөнхий хороо болон тэдгээртэй адилтгах төрийн байгууллагын ажлын албаны албан тушаалын цалингийн сүлжээний АА-6.1, АА-6.3 зэрэглэлээр цалинждаг байна.

№	Албан тушаал	Албан тушаалын зэрэглэл	Албан тушаал эрхлэгчийн тоо
1.	Хэлтсийн дарга	АА-6.3	3
2.	Ажлын албаны гишүүд	АА-6.1	43
3.	Нийт		46

Ажлын албаны албан хаагчид нь төрийн алба хаагчийн цалингийн АА-6.1 зэрэглэлд хамаардаг тул “Төрийн албан хаагчийн цалингийн сүлжээ, доод жишгийг шинэчлэн тогтоох тухай” Засгийн газрын 2014 оны 10 дугаар сарын 11-ний өдрийн 332 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Улсын их хурал, Ерөнхийлөгч, Засгийн газар, Улсын дээд шүүх, Улсын ерөнхий прокурорын газар, Үндсэн хуулийн цэц, Хүний эрхийн үндэсний комисс, Төрийн албаны зөвлөл, Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, Сонгуулийн ерөнхий хороо болон тэдгээртэй адилтгах төрийн байгууллагын ажлын албаны албан тушаалын цалингийн сүлжээ”-ний АА-6.1 зэрэглэлээр дундаж цалингийн хэмжээг тооцож гаргав.

Албан тушаалын зэрэглэл	1	2	3	4	5	Сарын дундаж цалин
АА-6	691610	735470	779338	821779	864211	778 481.6 төгрөг
ХЭҮК-ын ажлын албаны албан хаагчийн цалин	691610		779338			735 474 төгрөг

Ажлын албаны албан хаагчид зарцуулах, төрөөс даах зардлыг тооцохдоо түүний үндсэн цалингаас гадна 1/ бүх төрлийн даатгал, 2/ хоол, унааны нэмэгдэл, 3/ ажилласан жилийн нэмэгдэл, 4/ зэрэг дэвийн нэмэгдэл, 5/ буцалтгүй тусламж, 6/ шагнал, урамшуулал зэрэг нэмэлт зардлыг нэмж тооцох шаардлагатай байдаг.

Эдгээрийн хэмжээг тодорхой тогтоох боломжгүй тохиолдолд нэг албан хаагчийн цалингийн дундаж хэмжээний 15%-иар нийтлэг зардлыг, 10%-иар дагалдах зардлыг, 30%-иар нэмэгдэл, урамшууллын зардлыг тооцох боломжтой юм.

Зардлын нэр	Цалингийн дундаж хэмжээ	Хувь	Нийт 23 албан хаагчдын зардлын хэмжээ /төгрөг/
Үндсэн цалингийн дундаж хэмжээ	735 474		16,915,902
Нийтлэг зардал	735 474	15%	2,537,385.3

Дагалдах зардал	735 474	10%	1,691,590.2
Нэмэгдэл, урамшууллын зардал	735 474	30%	5,074,770.6
Нийт			26,219,648

Материаллаг зардал¹⁸

№	Зардлын нэр	Нийт 23 албан хаагчдын зардлын хэмжээ /төгрөг/
1	Газрын төлбөр	511,819
2	Бичиг хэрэг	2,852,000
3	Гэрэл, цахилгаан	2,949,497
4	Түлш, халаалт	6,058,384
5	Тээвэр, шатахуун	6,904,393
6	Шуудан холбоо	7,056,676
7	Цэвэр, бохир ус	13,787,074
8	Ном хэвлэх, авах	1,259,135
9	Урсгал засвар	2,938,296
10	Хөрөнгө оруулалт	1,619,706
11	Нийт	39,064,304

Элэгдэл хорогдлын зардал¹⁹

№	Зардлын нэр	Хувь	дүн	Хорогдол /23 албан хаагчдын /тооцсон дүн
1	Техник, тоног төхөөрөмж	20%	800,000	3,680,000
2	Тавилга /ширээ сандал г.м/	10%	1,000,000	2,300,000
3	Ажлын өрөөний хэмжээ 8 м2	1,6%	4,364,179	1,605,998
4	Нийт			7,585,998

Төрд үүсэх нийт зардал

№	Зардлын нэр	Зардлын дүн
1	Хүний нөөцийн зардал	314,635,776

¹⁸ ХЗДХЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2010 оны 99 дүгээр тушаалын хавсралт 3

¹⁹ ХЗДХЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2010 оны 99 дүгээр тушаалын хавсралт 3

2	Материаллаг зардал	39,064,304
3	Элэгдэл хорогдлын зардал	7,585,998
	Нийт зардал	361,286,078

Хувилбарын үр нөлөөг тандан судалсан байдал:

Аргачлалын 6-д заасны дагуу сонгон авсан хуулийн төсөл боловсруулах хувилбарын үр нөлөөг аргачлалд заасны дагуу ерөнхий асуултуудад хариулах замаар дүгнэлтийг нэгтгэн гаргалаа.

Жич: Хүний эрх, эдийн засаг, нийгэм, байгаль орчинд үзүүлэх үр нөлөөг шалгуур асуултын дагуу тандсан байдлыг Хавсралт 2-ийн 1, 2, 3, 4 дүгээр хүснэгтээс үзнэ үү.

a. Хүний эрхэд үзүүлэх нөлөө

Хүний эрхийн хамгаалагчийн тухай хууль батлагдсанаар өөрийн болон хүний эрхийг хамгаалах түүний төлөө тэмцэх хувь хүний эрх зүйн боломж илүү сайжрах эерэг нөлөө үзүүлнэ.

b. Эдийн засагт үзүүлэх үр нөлөө

Хүний эрхийн хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай бие даасан хууль батлагдсанаар зөвхөн хүний эрхийн хамгаалагчийг хамгаалахтай холбоотой тусгай хараат бус, бие даасан байгууллага байгуулагдаж орон тоо, үйл ажиллагаатай нь холбогдох бүх зардлыг улсын төсвөөс гаргах шаардлага үүснэ.

c. Нийгэмд үзүүлэх үр нөлөө

Нийгэмд ямар нэгэн сөрөг нөлөө үзүүлэхгүй. Харин нийгэмд хүний эрхийн хамгаалалтын эрх зүйн орчин сайжрана.

d. Байгаль орчинд үзүүлэх үр нөлөө

Байгаль орчинд ямар нэгэн шууд болон шууд бус сөрөг нөлөө үзүүлэхгүй.

Зохицуулалтын хувилбарын харьцуулсан дүгнэлт:

Зардал үр өгөөжийн харьцааг зорилгод хүрэх боломжтой харьцуулан судалсны үндсэн дээр хувилбарын эерэг болон сөрөг талыг харьцуулан дүгнэлээ.

Гарч болох эерэг үр дагавар

Хүний эрхийн хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хууль баталсан тохиолдолд Хүний эрхийн хамгаалагчийг хамгаалах чиг үүрэг бүхий бие даасан байгууллага байгуулагдаж удирдлагаар хангах нөхцөл бүрдэнэ. Ингэснээр Хүний эрхийн хамгаалагч болон түүний эрх үүргийг хуулийн хүрээнд тодорхойлон, үйл

ажиллагааг бүрэн хянаж, түргэн шуурхай ажиллах боломж бүрдэх болно.

Гарч болох сөрөг үр дагавар

Хүний эрхийн хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хууль баталж, бие даасан байгууллага байгуулснаар улсын төсөвт их зардал үүсгэнэ.

Судалгаагаар Монгол Улсад Хүний эрхийн хамгаалагчийн эсрэг үйлдэгдсэн зөрчил, гэмт хэргийн талаарх, баримт сэлт, статистик мэдээ онцгой анхаарал татахуйц хэмжээнд харагдахгүй байгаа нь нэг талаасаа энэ төрлийн зөрчлийг дангаар ангилан бүртгэх хэмжээнд нөхцөл байдал үүсээгүй нөгөө талаас энэ төрлийн зөрчлийг хариуцах байгууллага тусад нь шинээр байгуулах нийгмийн шаардлага юун түрүүнд бий болоогүй гэж үзэх үндэслэл болж байна.

Монгол Улсад Хүний эрхийн хамгаалагчийн эсрэг үйлдэгдсэн зөрчил, гэмт хэргийн талаарх, баримт сэлт, статистик мэдээ байхгүй байгаа нь нөхцөл байдал нэн тэргүүнд шийдвэрлэх, бие даасан байгууллага байгуулж үйл ажиллагаа явуулах түвшинд асуудал хүрээгүй гэж үзэж болохоор байна.

Мөн Хүний эрхийн хамгаалагчийг хамгаалах тухай Загвар хуульд “Хүний эрхийн хамгаалагчийг хамгаалах механизмыг тусгайлсан байгууллага эсхүл эрх олгогдсон хараат бус байгууллага нэгж удирдан зохион байгуулах болно” гэж заасан. Энэ нь тухайн улс оронд хүний эрхийг хамгаалах хараат бус байгууллага байгаа бол түүнд энэ үүргийг хариуцуулах, хэрэв тийм байгууллага байхгүй бол шинээр байгуулах тухай ойлголт юм. Монгол Улсын хувьд дээрх дурдсан хараат бус байгууллага нь “Хүний эрхийн Үндэсний Комиссын” нэрээр нэгэнт бий болсон байна. Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1-т “Комисс нь Монгол Улсын Үндсэн хууль, хууль, олон улсын гэрээнд заасан хүний эрх, эрх чөлөөний тухай заалтын хэрэгжилтэд хяналт тавьж, хүний эрхийг сахин хамгаалах, хөхүүлэн дэмжих байгууллага мөн.” гэж зааснаас үзэхэд үйл ажиллагааны хамрах хүрээнд нь хүний эрхийн хамгаалагчийг хамгаалах асуудал зүй ёсоор багтаж байна.

Энэ тохиолдолд ижил чиг үүрэг бүхий хараат бус байгууллагыг зэрэгцүүлэн байгуулах нь үйл ажиллагааны давхардал үүсч, хүний эрхийг хамгаалах зорилгыг хангах үр нөлөө буурах сөрөг үр дагаврыг дагуулах магадлалтай. Иймд Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлалын 5.8.2-т заасны дагуу зардал нэмэгдэж, үр өгөөж буурч байгаа учир үр дүн муутай хувилбар юм.

Хувилбар 2. *Хүний эрхийн хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийг батлан Хүний эрхийн Үндэсний Комиссын дэргэд хороо байгуулах;*

Хүний эрхийн хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслийн 10 дугаар зүйлд заасан Хүний эрхийн үндэсний комиссын дэргэд бие даасан, хараат бус хороо байгуулах гэдгийг үндэслэн энэхүү боломжит хувилбарыг дэвшүүлсэн. Иймд Хууль тогтоомжийн тухай хуулийн “Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг

урьдчилан тандан судлах аргачлалын” 5.6.1, 5.6.2, 6, 7 дугаарт заасан Зорилгод хүрэх байдал болон зардал, үр өгөөжийн харьцаа, үр нөлөөг харьцуулан дүгнэж хувилбарын хүрээнд тодорхойлъя.

Зорилгод хүрэх байдал:

Хүний эрхийн хамгаалагчийг хамгаалах бие даасан байгууллага буюу хороо нь хүний эрхийн хамгаалагчийг хамгаалах, эрхийг нь зөрчихөөс урьдчилан сэргийлэх, түүнийг таслан зогсоох, хууль ёсны үйл ажиллагааг нь хөхиүлэн дэмжих хүрээнд зорилгод хүрэх байдлаараа эерэг үр дүнтэй байж болно.

Зардал, үр өгөөжийн харьцаа:

Зардлын хувьд бие даасан тусдаа байгууллага байгуулах 1 дэх хувилбартай харьцуулбал илүү хэмнэлттэй байх боломжтой.

Хүний эрхийн комиссын дэргэд тусдаа хороо шинээр бий болохтой холбоотойгоор зардлыг тооцож үзэхэд дараах байдлаар төсөөлөл гарч байна.

Хүний эрхийн хамгаалагчийг хамгаалах хорооны ажлын албаны албан хаагчдын дундаж цалингийн хэмжээг ХЭҮК-ын ажлын албаны албан хаагчдын цалин хөлстэй адилтган тооцсон бөгөөд эдгээр албан хаагчид нь Улсын их хурал, Ерөнхийлөгч, Засгийн газар, Улсын дээд шүүх, Улсын ерөнхий прокурорын газар, Үндсэн хуулийн цэц, Хүний эрхийн үндэсний комисс, Төрийн албаны зөвлөл, Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, Сонгуулийн ерөнхий хороо болон тэдгээртэй адилтгах төрийн байгууллагын ажлын албаны албан тушаалын цалингийн сүлжээний АА-6.1, АА-6.3 зэрэглэлээр цалинждаг байна.

Хүний эрхийн хамгаалагчийг хамгаалах хорооны ажлын албаны албан хаагчдийн дундаж цалингийн хэмжээг ХЭҮК-ын ажлын албаны албан хаагчдын цалин хөлстэй адилтган нь төрийн алба хаагчийн цалингийн АА-6.1 зэрэглэлд хамаарахаар тооцож “Төрийн албан хаагчийн цалингийн сүлжээ, доод жишгийг шинэчлэн тогтоох тухай” Засгийн газрын 2014 оны 10 дугаар сарын 11-ний Ерөнхийлөгч, Засгийн газар, Улсын дээд шүүх, Улсын ерөнхий прокурорын газар, Үндсэн хуулийн цэц, Хүний эрхийн үндэсний комисс, Төрийн албаны зөвлөл, Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, Сонгуулийн ерөнхий хороо болон тэдгээртэй адилтгах төрийн байгууллагын ажлын албаны албан тушаалын цалингийн сүлжээ”-ний АА-6.3 зэрэглэлээр дундаж цалингийн хэмжээгээр тооцож гаргав.

Төрд үүсэх нийт зардал

Нийт зардлын хэмжээ

Зардлын төрөл	Зардлын хэмжээ	Хүний нөөцийн хэрэгцээ	Нийт зардал
Хүний нөөцийн зардал	1,044,487	11	11,489,357
Материаллаг зардал	1,952,317	11	21,475,487
Нийт зардал			32,964,844

Дээрх хүснэгтээс харахад хүний эрхийн хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төсөлд тусгасан ажил үйлчилгээг хэрэгжүүлэхэд төрөөс нэг жилд дунджаар **32,964,844**/гучин хоёр сая есөн зуун жаран дөрвөн мянга найман зуун дөчин дөрвөн/ төгрөгийн зардал үүсэхээр байна. Гэхдээ шинэ тутам байгуулагдах энэхүү энэхүү Хорооны ажлын албаны ажлын ачаалал, хуулийн хамрах хүрээнээс шалтгаалан бүтэц, орон тоонд өөрчлөлт орох эсэхэд анхаарах шаардлагатай юм.

Хуулийн этгээдэд үүсэх нийт захиргааны зардлын дүнг тооцох

Нийт зардал = Стандарт үйл ажиллагааны зардал х Тоон үзүүлэлт

Үүрэг	Агуулга	Стандарт үйл ажиллагаа	Зардал (төг)	Тоон үзүүлэлт	Нийт зардал
хүний эрхийн хамгаалагчид халдахаас урьдчилан сэргийлэх ажлыг тогтмол зохион байгуулах	8.1.1.Урьдчилан сэргийлэх арга хэмжээний төлөвлөгөө боловсруулах	Үүрэгтэй танилцах	252	2	504
		Мэдээлэл цуглуулах	10080	2	20.160
		Санхүүгийн тооцоо гаргах	1680	2	3.360
		Мэдээлэл, өгөгдөхүүнийг нягтлах	420	2	840
		Дотоод хуралдаан	2520	2	5.040
		Алдааг засах	1680	2	3.360
		Нийт			33.264
	8.1.1.Арга хэмжээ зохион байгуулах	Үүрэгтэй танилцах	252	2	504
		Бусадтай хамтран хийх хуралдаан	2520	2	5.040
		Мөнгө шилжүүлэх үүрэг хэрэгжүүлэх	672	2	1344
		Олшруулах,	420	2	840

		архивлах, тараах			
		Нийт			7.728
Нийт зардал					40.992

Хувилбарын үр нөлөөг тандан судалсан байдал:

Аргачлалын 6-д заасны дагуу өмнөх үе шатанд сонгон авсан хуулийн төсөл боловсруулах хувилбарын үр нөлөөг аргачлалд заасны дагуу ерөнхий асуултуудад хариулах замаар дүгнэлтийг нэгтгэн гаргалаа.

Жич: Хүний эрх, эдийн засаг, нийгэм, байгаль орчинд үзүүлэх үр нөлөөг шалгуур асуултын дагуу тандсан байдлыг Хавсралт 2-ийн 1, 2, 3, 4 дүгээр хүснэгтээс үзнэ үү.

А. Хүний эрхэд үзүүлэх нөлөө

Хүний эрхийг хамгаалах цар хүрээний өргөжих, үйл ажиллагаа нь чанаржих боломжтой.

В. Эдийн засагт үзүүлэх үр нөлөө

Хүний эрхийн Үндэсний Комиссын дэргэд шинээр “хороо” байгуулснаар улсын төсвөөс жил бүр дунджаар **32,964,844** төгрөгийн зардлыг санхүүжүүлэх шаардлага гарна. Харин хуулийн этгээдийн тухайд тухайн хуулийн этгээдээс жил бүр **40.992** төгрөгийн зардал оролцоогоор гарах шаардлагатай болно.

С. Нийгэмд үзүүлэх үр нөлөө

Нийгэмд ямар нэгэн сөрөг нөлөө үзүүлэхгүй. Харин хүний эрхийн хамгаалалт сайжрах нөхцөл бүрдэнэ.

Д. Байгаль орчинд үзүүлэх үр нөлөө

Байгаль орчинд ямар нэгэн шууд болон шууд бус сөрөг нөлөө үзүүлэхгүй.

Зохицуулалтын хувилбарын харьцуулсан дүгнэлт:

Зардал үр өгөөжийн харьцааг зорилгод хүрэх боломжтой харьцуулан судалсны үндсэн дээр дээр хувилбарын эерэг болон сөрөг талыг харьцуулан дүгнэлээ.

Гарч болох эерэг үр дагавар

Хүний эрхийн хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хууль батлагдаж Хүний эрхийн Үндэсний Комиссын дэргэд хороо байгуулагдсан тохиолдолд бүтэц өргөжиж хүний нөөц нэмэгдсэнээр үйл ажиллагаанд илүү ахиц гарах боломжтой.

Гарч болох сөрөг үр дагавар

Хүний эрхийн хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хууль батлагдаж Хүний эрхийн Үндэсний Комиссын дэргэд хороо байгуулах нь улсын төсөвт тодорхой хэмжээний зардал үүсгэнэ.

Монгол Улсад Хүний эрхийн хамгаалагчийн эсрэг үйлдэгдсэн зөрчил, гэмт хэргийн талаарх, баримт сэлт, статистик мэдээ байхгүй байгаа учир одоогийн нөхцөл байдалд шинээр бүтэц байгуулахыг нэн тэргүүний шийдвэрлэх асуудал гэж үзэхээргүй байна. Мөн Хүний эрхийн Үндэсний Комисс гэсэн бие даасан байгууллагын дэргэд дахин бие даасан хороо байгуулах нь үйл ажиллагааны зөрчил, давхардалд хүргэж болзошгүй.

Хувилбар 3. *Хүний эрхийн хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийг батална. Хүний эрхийн хамгаалагчийг хамгаалах, удирдлагаар хангах чиг үүргийг одоогийн Хүний эрхийн үндэсний Комисст хүлээлгэнэ. Ингэхдээ хуульд тодорхой бүтэц, орон тоо заахгүй.*

Хүний эрхийн Үндэсний комиссын тухай хуулийн 3.1-т “Комисс нь Монгол Улсын Үндсэн хууль, хууль, олон улсын гэрээнд заасан хүний эрх, эрх чөлөөний тухай заалтын хэрэгжилтэд хяналт тавьж, хүний эрхийг сахин хамгаалах, хөхүүлэн дэмжих байгууллага мөн” гэх заалтаас үзэхэд Хүний эрхийн Үндэсний комисс нь хүний эрхийн хамгаалагчийг хамгаалахтай холбоотойгоор нэмэлт чиг үүргийг хэрэгжүүлэх эрх зүйн бүрэн боломжтой.

Иймд Хууль тогтоомжийн тухай хуулийн “Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлалын” 5.6.1, 5.6.2, 6, 7 дугаарт заасан Зорилгод хүрэх байдал болон зардал, үр өгөөжийн харьцаа, үр нөлөөг харьцуулан дүгнэж хувилбарын хүрээнд тодорхойлъя.

Зорилгод хүрэх байдал:

Хувилбар гурвын хувьд авч үзвэл Хүний эрхийн хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хууль батлагдан хүний эрхийн хамгаалагч гэж хэн болох түүний эдлэх эрх, хүлээх үүргийг хуульчлах давуу талтай, Ингэснээр Хүний эрхийн хамгаалагчийн эрх зүйн байдал нь тодорхой болж хүний эрхийг хангах, хамгаалах, дэмжих боломж нөхцөлөөр хангагдана. Энэ боломжийг зардал гаргахгүй буюу шинээр бие даасан байгууллага эсхүл нэмэлт бүтэц байгуулахгүйгээр, үйл ажиллагааны чиглэлийг харгалзан одоогийн Хүний эрхийн Үндэсний Комисст хариуцуулах нь зорилгод хүрэх байдлаараа өмнөх хоёр хувилбараас дордохгүй зөрчил, давхардал үүсэхгүй байх давуу талтай байж болно.

Зардал, үр өгөөжийн харьцаа:

Хүний эрхийн хамгаалагчийг хамгаалах чиг үүргийг Хүний эрхийн Үндэсний комисст хариуцуулснаар чиг үүрэг нь өргөжих, хүний эрхийг хамгаалах үйл

ажиллагааны үр нөлөө нь дээшлэх ба энэ үүргийг өөр байгууллага эсхүл бүтэц байгуулахгүйгээр үндсэн үйл ажиллагаанд нь хамааруулан гүйцэтгүүлэх нь үр өгөөжөөр өмнөх хоёр хувилбараас илүү байх магадлалтай мөн зардлын хувьд хамгийн хэмнэлттэй юм.

Хувилбарын үр нөлөөг тандан судалсан байдал:

Аргачлалын 6-д заасны дагуу өмнөх үе шатанд сонгон авсан хуулийн төсөл боловсруулах хувилбарын үр нөлөөг аргачлалд заасны дагуу ерөнхий асуултуудад хариулах замаар дүгнэлтийг нэгтгэн гаргалаа.

Жич: Хүний эрх, эдийн засаг, нийгэм, байгаль орчинд үзүүлэх үр нөлөөг шалгуур асуултын дагуу тандсан байдлыг Хавсралт 2-ийн хувилбар 3 гэсэн хэсгээс үзнэ үү.

A. Хүний эрхэд үзүүлэх нөлөө

Хууль батлагдсанаар хүний эрхийг хамгаалах эрх зүйн орчин илүү сайжран үр нөлөө нь дээшлэнэ.

B. Эдийн засагт үзүүлэх үр нөлөө

Хүний эрхийн үндэсний Комисст хүлээлгэсэн үүргийн хүрээнд тодорхой хэмжээнд орон тоо нэмэгдэх бөгөөд улсын төсөвт маш бага хэмжээний нэмэгдэл зардал үүсгэнэ.

C. Нийгэмд үзүүлэх үр нөлөө

Нийгэмд ямар нэгэн сөрөг нөлөө үзүүлэхгүй. Харин хүний эрхийг хамгаалах нөхцөл байдал сайжрана.

D. Байгаль орчинд үзүүлэх үр нөлөө

Байгаль орчинд ямар нэгэн шууд болон шууд бус сөрөг нөлөө үзүүлэхгүй.

Зохицуулалтын хувилбарын харьцуулсан дүгнэлт:

Зардал үр өгөөжийн харьцааг зорилгод хүрэх боломжтой харьцуулан судалсны үндсэн дээр дээр хувилбарын эерэг болон сөрөг талыг харьцуулан дүгнэлээ.

Гарч болох эерэг үр дагавар

Хүний эрхийн хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хууль батлагдсанаар Хүний эрхийн хамгаалагч гэж хэн болох түүний эдлэх эрх, хүлээх үүргийг хуульчлах эрхийг хангах, хамгаалах, дэмжих үйл ажиллагаа түргэн шуурхай аливаа нөлөөллөөс ангид байдлаар явуулах боломж нөхцөл хангагдана.

Хүний эрхийн хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хууль батлагдан хэрэгжиж эхэлмэгц зардал үүсэхгүй.

Хүний эрхийн хамгаалагчийг хамгаалах чиг үүргийг Хүний эрхийн Үндэсний Комисс дангаараа хариуцан ажилласнаар илүү үр дүн гарах боломжтой.

Гарч болох сөрөг үр дагавар

Хүний эрхийн Үндэсний Комисст Хүний эрхийн хамгаалагчийг хамгаалах чиг үүргийг бий болгосноор ажлын ачаалал ихсэж хүний нөөц, орон тоог нэмэх шаардлага гарч болно. Энэ чиг үүрэг, үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд Хүний эрхийн Үндэсний Комисст тодорхой хугацаанд арга, туршлага дутаж болно.

Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, бусад хуультай нийцэж байгаа эсэх

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 16.10-т “...нийгмийн болон өөрсдийн ашиг сонирхол, үзэл бодлын үүднээс нам, олон нийтийн бусад байгууллага байгуулах, сайн дураараа эвлэлдэн нэгдэх эрхтэй...”, Гучин наймдугаар зүйлийн 38.7-д “хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, нийгмийн хэв журмыг бэхжүүлэх, гэмт хэрэгтэй тэмцэх арга хэмжээ авч хэрэгжүүлэх;” гэж тус тус Үндсэн хуульд заасан байна. Хүний эрхийн түгээмэл тунхаглалын Наймдугаар зүйлд “Үндсэн хууль болон бусад хуулиар олгосон үндсэн эрх нь зөрчигдвөл хүн бүр эрх мэдэл бүхий үндэсний шүүхээр эрхээ бүрэн сэргээн тогтоолгох эрхтэй.”, Хорин гуравдугаар зүйлд “хүн бүр эрх ашгаа хамгаалах зорилгоор үйлдвэрчний эвлэл байгуулах буюу үйлдвэрчний эвлэлд нэгдэх эрхтэй” гэж зааснаас үзэхэд хүн бүр ганцаар болон бусадтай эвлэлдэн нэгдэж эрхээ хамгаалах болон хамгаалуулах эрхтэй ба Монгол Улсын Үндсэн хууль болон Монгол Улсын олон улсын гэрээ, бусад хууль болон Олон Улсын баримт бичиг буюу “Нийтээр хүлээн зөвшөөрсөн хүний эрх, үндсэн эрх чөлөөг хамгаалах, хөхиүлэн дэмжих хувь хүн, нийгмийн нэгж, байгууллагын эрх, үүргийн тунхагтай нийцэж байна.

ДӨРӨВ.ОЛОН УЛСЫН БОЛОН БУСАД УЛСЫН ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТТАЙ ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ

Олон улс дахь зохицуулалт

1999 онд Нэгдсэн Үндэстний байгууллагын Ерөнхий ассамблейгаас “Нийтээр хүлээн зөвшөөрсөн хүний эрх, үндсэн эрх чөлөөг хөхиүлэн дэмжиж, хамгаалж буй хувь хүн, нийгмийн бүлгүүд, байгууллагуудын эрх, үүрэг хариуцлагын талаарх тунхаглал” (Хүний эрхийн хамгаалагчдын эрхийн тунхаглал)-ыг батлан гаргажээ. Уг тунхаглалаар бусдын эвлэлдэн нэгдэх эрх, олон улсын түвшинд хүний эрх, эрх чөлөөг хамгаалахыг тунхаглан, хүний эрхийн хамгаалагчийн талаарх ойлголт, зөвлөмжүүдийг тусгасан байдаг. Мөн НҮБ-аас Хүний эрхийн хамгаалагчийг хамгаалах загвар хуулийг гаргасан бөгөөд улс орнууд хууль тогтоомждоо заавал тусгавал зохих үзэл санаа, хэрэгжүүлэх механизмын талаар тусгасан байна.

Мөн 2014 онд Филиппин улсын Манила хотод зохион байгуулсан Азийн бүсийн

хүний эрхийг хамгаалагчийн Чуулганаар “Манилагийн хоёрдугаар тунхаглал”-ыг баталсан бөгөөд түүнд хүний эрхийг хамгаалагчийн үйл ажиллагаа явуулах орон зай, эрх чөлөө нь хязгаарлагдаж, эрсдэл, бэрхшээл тулгарч байгааг анхаарч, хуульд нийцсэн үйл ажиллагааны төлөө эрүүгийн хариуцлага хүлээлгэх, хязгаарлах, аливаа заналхийлэл, дарамт шахалтыг зогсоож, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүний эрхийн хамгаалагчийн тухай тунхаглалын зарчмыг баримтлахыг бүс нутгийн улс орнуудад уриалсан байна.²⁰

Хүний эрхийн хамгаалагчийг хэрхэн хамгаалж байгаа тухай гадаад орнуудын хууль тогтоомжийг харьцуулан судлахад дагнасан хууль батлан хэрэгжүүлэх эсхүл бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах замаар баталгаажуулах гэсэн 2 хэлбэр байна.

Нэгдүгээр чиглэлийг баримталсан орнууд нь ихэвчлэн өндөр хөгжилтэй, эрх зүйн соёл, иргэний нийгмийн төлөвшилтийн хувьд олон жилийн туршлагатай АНУ, Англи, Канад гэх мэт орнууд байна. Харин хоёр дахь хувилбарыг баримталж буй орнуудад ажиглагдаж буй нийтлэг жишиг бол төрийн хяналт, шалгалт ихтэй, цагдаажсан буюу цэрэгжсэн гэж хэлж болох орнууд багтжээ. Эдгээр орнууд дахь хүний эрхийн хамгаалагчдын нөхцөл байдал маш хүнд, амь насанд аюул заналхийлэх тулгарах тохиолдол өндөр байна.²¹

Хүний эрхийн хамгаалагчийн үйл ажиллагааны баталгаа, хамгаалалтыг хууль тогтоомжоор дэмжих зорилгоор дэлхийн 40 гаруй улс²² хүний эрхийн хамгаалагчийн эрхийг баталгаажуулах ямар нэг алхам хийжээ. Эдгээрээс Гуатамэла, Мексик, Индонез, Непал, Филиппин гэсэн 5 улс бие даасан хууль батлан хэрэгжүүлж байгаа бол бусад орнууд бие даасан хууль батлахгүйгээр хууль тогтоомждоо нэмэлт, өөрчлөлт оруулах замаар хүний эрхийн хамгаалагчийн эрхийг хангаж байна. Тодруулбал Латин Америкт Колумб, Гондурас, Бразил зэрэг олон орон хүний эрхийн хамгаалагчид болон бусад эрсдэлд орсон бүлгүүдийг хамгаалах, урьдчилан сэргийлэх арга хэмжээгээр хангах үндэсний хамгаалалтын механизм байгуулсан байна. Гэсэн хэдий ч ийм механизмуудын бүрдүүлсэн нөөц, үр дүнтэй хэрэгжүүлэх бололцоо дутмаг байгаад тухайн орны иргэний нийгмийн байгууллагууд санаа зовниж буйгаа илэрхийлсэн.²³

Зааны ясан эрэг, Ардчилсан Бүгд найрамдах Конго зэрэг бусад оронд хүний эрхийн хамгаалагчдын хамгаалах зорилготой хууль тогтоомжийн талаар хэлэлцэж байгаа талаар Эмнести интернэшнл байгууллагын тайланд дурджээ.

“Front Line Defenders” олон улсын хүний эрхийн хамгаалагчдын холбооны тайланд дурдсанаар 2015 оны 11 сарын байдлаар 25 улсад нийт 156 хүний эрхийн хамгаалагчийн амь насыг хохироосон гэсэн баримтыг мэдээлсэн байна. Энэ нь өмнөх онтой харьцуулахад хүний эрхийн хамгаалагчийн амь насыг хохироосон тохиолдол болон энэ төрлийн гэмт хэрэг үйлдэгдэх орны тоо нэмэгдсэн үзүүлэлттэй гарчээ.

²⁰ Хүний эрхийн хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл.

²¹ Б.Болорчулуун. Хүний эрхийн хамгаалагчийн хамгаалахад тулгамдаж буй асуудал, гадаад орны туршлага. 2017 он.

²² Хүний эрхийн хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслийн танилцуулга. 1 дэх тал.

²³ Аюул дундах хүний эрхийн хамгаалагчид. Эмнести интернэшнл. 2017.

Эдгээр гэмт хэрэг гарсан орнуудыг авч үзвэл Афганистан, Азербайжан, Бангладеш, Бразил, Колумб, Египет, Эль Сальвадор, Гватемал, Гондурас, Энэтхэг, Индонез, Ирак, Ливи, Мексик, Мьянмар, Никарагуа, Пакистан, Филиппин, Сомали, Хойд Судан, Судан, Сири, Тайланд, Турк, Йемен зэрэг улсуудаас ирсэн бөгөөд бараг тал хувь нь Латин Америкийн орнуудад үйлдэгдэж байна.

Филиппин улс нь хүний эрхийн хамгаалагчийн амь насыг хохироосон тоогоороо хамгийн аюултай улсын жагсаалтын 2-т бичигддэг.²⁴

Хүний эрхийн хамгаалагчдын ажлыг тогтмол сайн хамгаалах, дэмжихээр үндэсний түвшинд анхаарал хандуулсан зарим улс орнуудын талаар товч авч үзлээ. Тэдгээрээс дурдвал:

Филиппин Улс

Филиппин Улсын парламентаас 2011 онд Хүний эрхийн хамгаалагчийн тухай хуулийг батлан хэрэгжүүлж эхэлжээ. Хуулиар хүний эрхийн хамгаалагчийн эрх болон түүнийг хэрэгжүүлэх байгууллагын тогтолцоо зэргийг хуульчилсан байна.

Тус хуулиар Хүний эрхийн хамгаалагчийг тодорхойлсон бөгөөд хүний эрх, эрх чөлөөний аливаа хэлбэрийг хүндэтгэн, хөгжүүлэх, танин мэдэхүйг дэмжих, хүний эрхийг хүндэтгэх явдлыг хөхиүлэн дэмжиж ажиллах, шударга хувь хүн, хүний эрхийн байгууллагыг ойлгохоор заасан байна. Харин хүний эрхийг хамгаалах, сурталчлах, хэрэгжүүлэх зэрэг аль нэгийг нь үндсэн зорилгоо болгосон Төрийн бус байгууллага болон холбоог хүний эрхийн байгууллагад хамааруулан ойлгохоор хуульчилжээ.

Хуулиар хүний эрхийн хамгаалагчийг аливаа хүчирхийлэл, заналхийлэл, өс хонзон, хуульд заасан эсвэл бодит байдалд хэвшсэн ялгаварлан гадуурхалт, дарамт болон бусад зоргоор хийх үйлдэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах үүргийг засгийн газарт оногдуулсан байна.

Мөн захиргааны хариуцлагын дагуу бүх ажилчин болон ахлан албан тушаалтан захиргааны акт гаргахдаа хүний үндсэн эрх, эрх чөлөөг зөрчихгүй байх, байгууллага болон өндөр албан тушаалтнууд иргэний үндсэн эрхийг хэрэгжүүлэх, хамгаалах явдлыг хязгаарласан захиргааны акт гаргахад тухайн албан хаагч оролцохоос татгалзсан үйлдэлд хариуцлага тооцдоггүй байна.

Хуульд заавал эдлэх 16 эрхийн тухай дурдсан байна. Хүний эрхийн хамгаалагч нь ганцаар буюу бусадтай эвлэлдэн нэгдэж тайван замаар уулзалт, цуглаан хийх, Төрийн бус байгууллага, эвсэл холбоо, бүлэгт нэгдэх, оролцох, Төрийн бус байгууллага болон засгийн газар хоорондын байгууллагатай харилцах эрхтэй байна. Хүн бүр, ганцаар болон бусадтай эвлэлдэн нэгдэж, Хүний бүхий л эрх, эрх чөлөөний тухай мэдээллийг, түүний дотор эдгээр эрх, эрх чөлөө нь дотоодын хууль тогтоох, шүүх болон захиргааны тогтолцоонд хэрхэн тусгагдсан талаарх мэдээллийг мэдэх, эрж хайх, олох, хүлээж авах болон хадгалах, хүний бүхий л эрх, эрх чөлөөний талаарх мэдлэг, мэдээллийг чөлөөтэй хэвлэн нийтлэх, бусадтай хуваалцах, түгээн

²⁴ Front Line defenders – 2016 Annual Report, p.5.

дэлгэрүүлэх, хүний бүхий л эрх, эрх чөлөөг хууль зүйн болон бодит амьдралд мөрдөж баримтлах тухай ойлголтыг хэлэлцэх, бий болгох, агуулах, мөн эдгээр болон бусад тохиромжтой арга хэрэгслээр энэ асуудалд олон нийтийн анхаарлыг хандуулах эрхтэй байна.

Хүн бүр, ганцаар болон бусадтай эвлэлдэн нэгдэж, Хүний эрхийн шинэ үзэл баримтлалыг хэлэлцэх, боловсруулах хүлээн зөвшөөрөхийг дэмжих, эвлэлдэн нэгдэж, ялгаварлан гадуурхалтаас ангид нөхцөлд өөрийн орны төр, засгийн ажил, нийтийн үйл хэргийг удирдан явуулахад оролцох бодит боломжтой байх, төрийн байгууллага, агентлаг, нийтийн үйл хэрэгт хамааралтай байгууллагад чиг үүргийг нь боловсронгуй болгох санал, шүүмж өгөх, хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэн биелүүлэх, хөхиүлэн дэмжих, хамгаалахад саад тотгор учруулж болох тэдгээрийн үйл, ажиллагааны аливаа асуудалд анхаарлыг нь хандуулах эрхтэй байна.²⁵

Хүний эрх, эрх чөлөөний асуудлаар гомдол хүлээн авах, хэлэлцэх ерөнхий буюу тусгай эрх бүхий олон улсын байгууллагуудтай хүний эрх, эрх чөлөөний асуудлаар саадгүй холбогдох, тэдгээрт гомдол гаргах эрхтэй бөгөөд хүний эрх, эрх чөлөөний зөрчлийн эсрэг үйл ажиллагаанд оролцох, тайван замаар тухайлан хүний эрх, эрх чөлөөг хөхиүлэн дэмжих, хамгаалах зорилгоор нөөц боломжийг шаардах, хүлээн авах болон ашиглах эрхтэй байна.²⁶

Итали Улс

Тус улс нь хүний эрхийн хамгаалагчийг хамгаалах чиглэлээр ихээхэн анхаарал тавьдаг улс бөгөөд бие даасан хууль батлахгүйгээр энэхүү үйл ажиллагаагаа явуулдаг онцлогтой.

Итали Улс 1946 онд бүх нийтийн санал асуулгаар хаант засгаас татгалзсанаараа төрийн байгууламжийн хувьд нэгдмэл, төрийн хэлбэрийн хувьд парламентын эрх мэдэл давамгай Бүгд Найрамдах засагтай улс болсон. Төрийн тэргүүн буюу Ерөнхийлөгч нь зөвхөн нэг удаа, долоон жилээр парламентын хоёр танхимын хамтын шийдвэрээр сонгогддог. Итали Улсад Парламентаа хувь тэнцүүлэх (пропорционал) аргаар сонгож байна. (2005 онд сонгуулийн хуульд нэмэлт өөрчлөлт оруулахаас өмнө сонгуулийн холимог тогтолцоо буюу 630 төлөөлөгчдийн 1/4 пропорционал, 3/4 мажоритар аргаар сонголтоо хийдэг байв).

Freedom House Олон улсын байгууллагаас Италийн хэвлэл мэдээллийн эрх чөлөөг "бүрэн бус чөлөөтэй" гэж үнэлсэн байна.²⁷

Итали Улсын засгийн газрын зүгээс хүний эрхийн хамгаалагчийг хамгаалах ажлын хүрээнд гол дуу хоолой болсон сэтгүүлчдийн эрхийг хүндэтгэхээ мэдэгдсэн. Ингэхдээ хэвлэл мэдээллийн бие даасан байдлыг хангах, олон ургалч

²⁵ Филиппин Улсын Хүний эрхийн хамгаалагчийн тухай хууль. 8 дугаар зүйл.

²⁶ Филиппин Улсын Хүний эрхийн хамгаалагчийн тухай хууль. 12 дугаар зүйл.

²⁷ freedomhouse.org/sites/default/files/Freedom%20of%20the%20Press%202013%20Maps%20for%20Website.pdf

үзлийг дэмжих, сэтгүүлчид дуу хоолойгоо чөлөөтэй илэрхийлэх боломжийг бүрдүүлэхэд дэмжиж ажиллахаа амлажээ.

Хүний эрхийн олон улсын үйлчилгээний байгууллагаас 2014 онд Итали улсын засгийн газарт өгсөн зөвлөмжид²⁸Итали Улсад хүний эрхийн төлөө тэмцэгчдэд учирч буй эрсдэлийг дараах байдлаартодорхойлсон байна. Тухайлбал:

- Хүний эрхийг хамгаалах явцад хамгийн их бэрхшээл учруулж буй асуудал бол чөлөөт сэтгүүл зүйг саад хийх, хуулийг уруулан ашиглах замаар иргэний өөрийгөө чөлөөтэй илэрхийлэхэрхийг хязгаарлах явдал түгээмэл байна;
- Олон нийтийн эсэргүүцлийн эсрэг хүч хэрэглэхийг буруушаасан шүүхийнпрактик байгаа боловч энэ төрлийн үйлдэл дахин гарч болзошгүй байгааг анхааруулсаар байна;
- Италийн сэтгүүлчдэд анархист бүлгэмүүд болон мафийн халдлага, заналхийлэлд өртөх зэрэг эрсдэлүүд байсаар байна;
- Засгийн газар иргэний нийгэмтэйгээ зөвшилцөн, бие даасан Үндэсний Хүний Эрхийн Институт байгуулах шаардлагатай. Ингэхдээ Paris Principles-тэй нийцсэн, хэвлэл мэдээллийн эрх чөлөөнд зориулсан орон зай, хүний эрхийн хамгаалагчийн асуудлыг нарийвчлан авч үзэх, улмаар активистууд, босогчид, сэтгүүлчид, хохирогчдын эрх ашгийг хамгаалах чадамжтай байхаар байгуулах хэрэгтэй.

Тус зөвлөмжийг дагах, хангах, сайжруулахын тулд Итали Улсын 20 гаруй Төрийн тус байгууллага болон иргэний нийгмийн бүлгүүд, хүний эрхийн хамгаалагчийг эрсдэлээс хамгаалах, дэмжих ажлыг хамтран хийж байна.

ТАВ. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

Хүний эрхийн хамгаалагчийг хамгаалах явдал нь хүний эрхийг хамгаалах механизмын чухал нэг хэсэг хэмээн сүүлийн үеийн олон улсын баримт бичигт дурдсан төдийгүй гадаадын зарим орны хууль тогтоомжид тусгалаа олжээ. Харин Монгол Улсын хувьд энэхүү чиглэлээр эрх зүйн зохицуулалт жич хийгдэж байгаагүй шинэ төрлийн ойлголт болж байна.

Тус ойлголтын хүрээнд хүний эрхийн төлөө тэмцэгчийг бусдын халдлагаас хамгаалах, энэхүү үйл ажиллагаагаа идэвхтэй явуулах боломжийг олгох, мэдээллийн ил тод байдлыг бүрдүүлэх явдал үндэсний хэмжээнд чухлаар тавигдаж байна.

Монгол Улсын Үндсэн хуульд хүний эрхийн хамгаалагчийг хамгаалах талаар тусгайлсан зохицуулалт байхгүй боловч оршил хэсэг болон хоёрдугаар бүлгээс үзэхэд хүний эрхийн хамгаалагчийг хамгаалах суурь ойлголт үндсэн хуульд агуулагдсан хэмээн тайлбарлах боломжтой байна. Харин салбарын хууль

²⁸Хүний эрхийн олон улсын үйлчилгээний байгууллагаас Итали Улсын засгийн газарт гаргасан зөвлөмж. 2014. https://www.ishr.ch/sites/default/files/article/files/italy_-_ishr_briefing_paper_on_the_situation_of_hrds.pdfСүүлд зочилсон 2018.01.07-ны өдөр.

тогтоомжид энэ төрлийн зохицуулалт хангалттай тусгагдаагүй.

Монгол Улсад хүний эрхийг хамгаалах үйл ажиллагаа явуулсны төлөө амь нас, бие махбодод нь халдах, гэр бүл, найз нөхөд, хамаарал бүхий этгээдийг заналхийлэх, нэр төр алдар хүндийг гутаах, сэтгэл санааны дарамт үзүүлэх зэрэг явдал гарч байгаа нь хүний эрхийн хамгаалагчийг хамгаалах, хүний эрхийн төлөө үйл ажиллагааг нь идэвхтэй дэмжих хэрэгцээ, шаардлагатайг байгааг харуулж байна.

Монгол Улсын хууль тогтоомжид хүний эрхийг хамгаалахаар тэмцэж буй этгээдийг хамгаалах, үйл ажиллагааг нь дэмжихэд чиглэсэн зохицуулалт хангалтгүй байна. Одоогийн байдлаар цөөн тооны хуульд тусгагдсан зохицуулалт нь хоорондоо уялдаагүй байна.

Судалгааны үр дүнд зохицуулалтын хувилбаруудыг харьцуулан үзсэнээр хүний эрхийн хамгаалагчийг хамгаалахын тулд одоогийн тулгарч буй асуудлыг шийдвэрлэх хамгийн оновчтой арга зам бол бие даасан хууль батлах буюу хуулийн төсөл боловсруулах явдал мөн гэж дүгнэв. Хууль батлахтай холбогдуулан дараах онцлог бүхий 3 хувилбарыг дэвшүүлэв. Үүнд:

Хувилбар 1. Хүний эрхийн хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийг батлан энэ төрлийн чиг үүргийг хариуцсан бие даасан байгууллага байгуулах;

Хувилбар 2. Хүний эрхийн хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийг батлан Хүний эрхийн Үндэсний Комиссын дэргэд хороо байгуулах;

Хувилбар 3. Хүний эрхийн хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийг батална. Хүний эрхийн хамгаалагчийг хамгаалах, удирдлагаар хангах чиг үүргийг нэмэлт бүтэц батлахгүйгээр одоогийн Хүний эрхийн үндэсний Комисст хүлээлгэнэ. Ингэхдээ хуульд тодорхой бүтэц, орон тоо заахгүй гэсэн 3 хувилбарыг дэвшүүлсэн бөгөөд холбогдох дүгнэлт, саналыг өгөх нь судалгааны ач холбогдолтой байна.

Хувилбар 1-ын хувьд Хүний эрхийн хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хууль батлагдсанаар хүний эрхийн хамгаалагчийн үйл ажиллагааны баталгаа сайжрана. Ингэхдээ Монгол Улсад Хүний эрхийн хамгаалагчийн эсрэг үйлдэгдсэн зөрчил, гэмт хэргийн талаарх, статистик мэдээ онцгой анхаарал татсан хэмжээнд хүрээгүй байгаа учраас бие даасан байгууллага байгуулж их хэмжээний зардал гаргах шаардлагагүй гэж үзлээ.

Иймд Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлалын 5.8.2-тээсний дагуу зардал нэмэгдэж, үр өгөөж нь тэр хэмжээнд байх магадлал багатуул үр дүн муутай хувилбар гэсэн дүгнэлт хийв.

Хувилбар 2-ын хувьд тусгайлсан байгууллага байгуулах шаардлагагүй гэж үзсэн. Харин Хүний эрхийн хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төсөлд тусгаснаар Хүний эрхийн Үндэсний Комиссын дэргэд хороо байгуулах нь хувилбар нэгтэй харьцуулахад төсвийг хэмнэх хэдий ч хорооны үйл ажиллагаатай холбогдохнийлээд хэмжээний буюу төрөөс нэг жилд дунджаар **32,964,844/гучин хоёр**

сая есөн зуун жаран дөрвөн мянга найман зуун дөчин дөрвөн/ төгрөгийн²⁹ зардал гарахаар байна. Мөн Хүний эрхийн хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4 “хүний эрхийн хамгаалагчийн эрхийн зөрчлийн талаарх мэдээлэл, гомдлыг хүлээн авч, Хүний эрхийн Үндэсний Комисст шилжүүлэн шийдвэрлүүлэх”, 12.1.2.хүний эрхийн хамгаалагчийн хууль ёсны үйл ажиллагааг хөхиүлэн дэмжих” гэж хуулийн төсөлд оруулснаас харахад Хүний эрхийн Үндэсний Комиссын гэсэн бие даасан, хараат бус байгууллагын дэргэд дахин бие даасан хороо байгуулах нь зохимжгүй бөгөөд чиг үүрэг, үйл ажиллагааны давхардал, зөрчил үүсч болно.

Хувилбар 3-ын тухайд Хүний эрхийн хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийг батлан энэ төрлийн асуудлыг хариуцах, удирдлагаар хангах чиг үүргийг Хүний эрхийн Үндэсний Комисст хүлээлгэнэ. Энэ хувилбарыг хэрэгжүүлэхдээ Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах замаар Хүний эрхийн хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуультай нийцүүлнэ. Мөн бие даасан байгууллага, хороо шинээр байгуулахгүйгээр одоо байгаа адил чиг үүрэгтэй байгууллагад хариуцуулах нь улсын төсөвт ачаалал үүсгэхгүй байх, хамгийн бага зардлаар асуудлыг шийдвэрлэх боломжийг олгох давуу талтай юм. Хүний эрхийн Үндэсний комисст шинээр чиг үүрэг нэмсэнтэй холбогдуулан ажлын ачаалал нэмэгдэх, орон тоо дутах, санхүүгийн хүрэлцээгүй байдал үүсэх зэрэг асуудал тулгарвал Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.2 “Комиссын төсвийг түүний саналыг үндэслэн Улсын Их Хурал баталж улсын төсөвт тусгайлан тусгах бөгөөд энэхүү төсөв нь үйл ажиллагаагаа хараат бусаар хэрэгжүүлэх шаардлагыг хангасан байна.” гэж заасны дагуу үндсэн асуудлыг тухай бүр уян хатаншийдвэрлэх боломжтой.

Дээрх дүгнэлтүүдээс үзэхэд Хувилбар 3 нь бусад хоёр хувилбартай харьцуулахад “Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлал”-ын 5.8.1.-т “зохицуулалтын хувилбаруудын нийгэмд үзүүлэх үр өгөөжийг ерөнхий байдлаар тодорхойлно.

Зардал нэмэгдэх тохиолдолд тухайн хувилбарыг хэрэгжүүлснээр нийгэмд үзүүлэх үр өгөөж нь гарсан зардлаас илүү байхаар бол үр ашигтай гэж үзэн энэ тухай тайлбарлаж дүгнэлтэд оруулна” заасныг үндэслэн хамгийн бага зардлаар үр дүнд хүрнэ гэж тооцсон. Хувилбар 3-ийг мөн хамгийн үр дүн нөлөө сайтай болно гэж үзлээ.

Иймд Хүний эрхийн хамгаалагчийг хамгаалах эрх зүйн байдлын тухай хуулийн хэрэгцээ, шаардлага нэгэнт бий болсон учир төрөлжсөн хууль батлах төслийг дэмжиж байна.

Хүний эрхийг хамгаалах үндсэн чиг үүрэг бүхий бие даасан, хараат бус байгууллага болох Хүний Эрхийн Үндэсний Комисс нэгэнт байгаа учраас Хүний эрхийн хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хууль баталсан тохиолдолд шинээр тусдаа байгууллага, эсхүл бие даасан статустай бүтэц байгуулах шаардлагагүй гэж үзлээ.

²⁹Хүний эрхийн хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төсөлд хийсэн зардлын тооцооны тайлангаас дэлгэрүүлж үзнэ үү.

Уг хуулийг боловсруулан батлахдаа одоогийн Хүний эрхийн Үндэсний Комиссийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид сайтар нийцүүлсэн, амьдралд хэрэгжих, хэрэгжүүлэх боломжтойгоор маш сайн тооцож судалгаанд ирүүлсэн Хүний эрхийн хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслийг дахин боловсруулах хэрэгтэй гэсэн байр суурийг илэрхийлж байна.

Хавсралт 1

**ХҮНИЙ ЭРХИЙН ХАМГААЛАГЧИЙГ ХАМГААЛАХ ЗАГВАР ХУУЛЬД ТУСГАГДСАН
ҮЗЭЛ САНААНУУД ХУУЛИЙН ТӨСӨЛ БОЛОН БУСАД ХҮЧИН ТӨГӨЛДӨР
МӨРДӨГДӨЖ БУЙ ХУУЛЬ ТОГТООМЖИД ТУСГАГДСАН БАЙДАЛ**

№	Хүний эрхийн хамгаалагчийг хамгаалах загвар хууль	Хүчин төгөлдөр мөрдөгдөж буй бусад хууль, тогтоомж	Хүний эрхийн хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл
1	<u>Хүний эрх ба үндсэн эрх чөлөөг хөхүүлэн дэмжих ба хамгаалах эрх;</u> <i>/хүний эрх ба үндсэн эрх чөлөөг орон нутгийн, үндэсний, бүс нутгийн болон олон улсын хэмжээнд хөхүүлэн дэмжих болон хамгаалах/</i>	Монгол Улсын үндсэн хуулийн 2 дугаар бүлэг	Хуулийн төслийн 6.1-д хүний эрхийн хамгаалагч нь дараах эрхтэй. 6.1.1-д “Монгол Улсын үндсэн хууль, бусад хууль, олон улсын гэрээгээр баталгаажуулсан хүний эрх, эрх чөлөөг хөхиүлэн дэмжих, хамгаалах үйл ажиллагаа явуулах”
2	<i>Эвлэлдэн нэгдэх, бүлэг, байгууллага байгуулах эрх; /хүний эрх болон үндсэн эрх чөлөөг хөхүүлэн дэмжих ба хамгаалах тэмцлийг хэрэгжүүлэхийн төлөө албан ёсны ба албан бус, бүртгэлтэй эсхүл эс бүртгэлтэй бүлэглэл, төрийн бус байгууллагад нэгдэх, төрийн бус байгууллага, бүлэглэл байгуулах, бүлэглэлд оролцох/</i>	Монгол Улсын үндсэн хуулийн 16.18-д “Нийгмийн болон өөрсдийн ашиг сонирхол, үзэл бодлын үүднээс нам, олон нийтийн бусад байгууллага байгуулах, сайн дураараа эвлэлдэн нэгдэх эрхтэй”, ТББТХ-ын 1 дүгээр зүйл “Энэ хуулийн зорилт нь Үндсэн хууль болон Монгол Улсын олон улсын гэрээгээр тодорхойлсон хүний эрхийг хэрэгжүүлэх зорилгоор иргэд эвлэлдэн нэгдэх, төрийн бус байгууллагыг үүсгэн байгуулах болон төрийн бус байгууллагын үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулахад	Төслийн 6.1-д Хүний эрхийн хамгаалагч нь дараах эрхтэй. 6.1.2-д “хүний эрх, эрх чөлөөг эдлүүлэх, хамгаалах зорилгоор албан болон албан бусаар төрийн бусбайгууллага, эвсэл холбоо, бүлэг, түүнтэй адилтгах нэгдэл байгуулах, эвлэлдэн нэгдэх, үйл ажиллагаанд нь оролцох:

		оршино..." болон холбогдох бусад заалт.	
3	Мэдээлэл шаардах, олж авах, боловсруулах эрх; <i>/хүний эрх болон үндсэн эрх чөлөөг хөхүүлэн дэмжих, хамгаалах, хэрэгжүүлэх зорилгоор төрийн, засгийн газар хоорондын, хүмүүнлэгийн болон хувийн байгууллага болон орон нутгийн ба олон улсын эх үүсвэрээс мэдээлэл шаардах, олж авах болон ашиглах/</i>	Монгол Улсын үндсэн хуулийн 16.17-д "төр, түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрх...", Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай, Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай зэрэг хуулиудаар зохицуулсан байна.	Төслийн 6.1-д Хүний эрхийн хамгаалагч нь дараах эрхтэй. 6.1.6-д "хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, хангахад шаардлагатай хууль тогтоомжоор төрийн болон бусад байгууллага, хувь хүний нууцад хамаарахаас бусад мэдээллийг төр, хувийн хэвшил, иргэний нийгмээс аливаа хэлбэрээр хүлээж авах, эрж хайх, олох, мэдэх, хэвлэн нийтлэх, хадгалах, бусадтай хуваалцах"
4	Мэдээлэл хайх, олж авах болон тараах эрх; <i>/Хүний эрх, үндсэн эрх чөлөөг хууль, шүүх болон захиргааны журмаар хэрхэн хангаж байгаа талаар мэдэх, мэдээлэл хайх, хүртэх, олж авах, авах болон хадгалах/</i>	Төрийн албаны тухай хуулийн 4.2."Хуульд өөрөөр заагаагүй бол төрийн албанд дараах зарчмыг баримтална: 4.2.2. ил тод байх" Шүүхийн тухай хуулийн 8.1."Шүүхийн үйл ажиллагаа олон нийтэд нээлттэй, ил тод байна."	Төслийн 6.1.6 дугаар зүйлийг хамааруулан ойлгож болохоор байна. Гэвч Олон Улсын загвар хуульд аливаа эх үүсвэрээс мэдээлэл олж авах эрх болон төрийн байгууллагын үйл ажиллагааны талаарх мэдээлэл олж авах эрхийг ялгамжтайгаар тодорхойлжээ.
5	7-р зүйл Хүний эрхийн үзэл санааг хөгжүүлэх болон өмгөөлөх эрх; <i>/хүний эрх, үндсэн эрх чөлөөтэй холбоотой үзэл санаа, зарчмыг хөгжүүлэх, хэлэлцэх болон нийтээр хүлээн зөвшөөрүүлэхээр үзэл санаагаа хамгаалах/</i>	Хүний эрхийн үндэсний комиссын тухай хуулийн 3.1. "Комисс нь Монгол Улсын Үндсэн хууль, хууль, олон улсын гэрээнд заасан хүний эрх, эрх чөлөөний тухай заалтын хэрэгжилтэд хяналт тавьж, хүний эрхийг сахин хамгаалах, хөхүүлэн дэмжих байгууллага мөн.	Энэ талаар төсөлд дурдаагүй байна.
6	8-р зүйл Төрийн бус, төрийн болон засгийн газар хоорондын байгууллагатай	Олон улсын гэрээний тухай хууль	Энэ талаар төсөлд дурдаагүй байна.

	харилцах эрх; /хүний эрх болон үндсэн эрх чөлөөний талаар эрх бүхий төрийн бус, төрийн болон засгийн газар хоорондын байгууллага, үүний дотор тэдгээрийн салбар байгууллага, механизм болон шинжээч, дипломат төлөөлөгчтэй харилцах/		
